

**Монгол хэлний халх аялгуу, түүний аман ба салбар аман аялгуунуудын
өнөөгийн байдал**

Гэрэлт-Одын БАТЗАЯА*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Хэл шинжлэлийн салбар

Received: 10 September 2025 / **Accepted:** 20 September 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй. Эрдэмтэн судлаачид монгол хэлний халх аялгууг 100 гаруй жил судлахдаа түүний доторх аман болон салбар аман аялгуунуудыг өөр өөрөөр нэрлэж, ангилж, иржээ. Тэдгээр нь хэлэлцэгчдийн угсаа гарал, түүхэн замнал, нүүдэл суурьшил, нутгийн аялгууны хөгжил хувьсал, улс орны хил хязгаар, нутаг орны байриил, улс төрийн үзэл баримтлал, нутгийн аялгуу судлалын ухааны хөгжил гэх мэт хэлний ба хэлний бус олон хүчин зүйлтэй холбоотой юм. Түүнээс гадна аливаа хэл, аялгуу бол тасралтгүй хувьсан хөгжиж байдаг учраас аливаа хувиралт өөрчлөлт байнга үргэлжилсээр байдаг. Иймээс аялгуунуудыг ангилан хуваах ажил бол нэг удаа, нэг хүн хийгээд орхих ажил биш, тодорхой хугацаанд дахин дахин судалж, шинэчилж байх хэрэгтэй ажил юм. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид 1950-1980-аад онд хээрийн шинжилгээний ангиудаар олон удаа явж, идэвхтэй судалж байсан тэр үеэс хойш өдгөө 40-70 жил өнгөрчээ. 1990-ээд оноос хойш ард иргэд амьдрах газраа чөлөөтэй сонгох эрхтэй болсон учир шилжилт хөдөлгөөн тасралтгүй өрнөсөөр байна. Өдгөө нутгийн аялгуугаа цэврээр хадгалж буй хүмүүс нэн цөөрснийг ч тэмдэглэх хэрэгтэй. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 2022-2024 онд хэрэгжүүлсэн “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” сэдэвт суурь судалгааны төслийн ажлын хүрээнд миний бие халх аялгууны өнөөгийн байдлыг судалсан судалгааныхаа үр дүнг товчоолон толилуулъя. Монгол хэлний халх нутгийн аялгуун дотор: Улаанбаатарын халх, төв халх (төв халх, өвөрхангайн халх, говийн халх), баруун халх (өрнөд халх, элжигин халх, сартуул), зүүн халх (дорнод халх, дарьганга, халхажсан өвөр монгол), халх-буриадын завсрын (цонгоол, хамниган) хэмээх таван аман аялгуу байна.

Түлхүүр үгс: аялгуу, аман аялгуу, завсрын аман аялгуу, салбар аман аялгуу; халх, Улаанбаатарын халх, төв халх, баруун халх, зүүн халх, халх-буриадын завсрын аман аялгуу

**The Current Status
of the Khalkh Dialect, and its Subdialects of Mongolian Language**

* © Г. Батзаяа, 2025, Email: batzaya.g@mas.ac.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Abstract: For over 100 years, Mongolian and Mongolist scholars studying the khalkha dialect of the Mongolian language itself have classified and named its subdialects differently. These variations are linked to numerous linguistic and non-linguistic factors, such as ethnic origin, historical development, migration patterns, the evolution of local dialects, national borders, political ideologies, and the advancement of dialectology. Furthermore, as any language or dialect undergoes continuous evolution, changes and transformations are always ongoing. Therefore, classifying and dividing languages and dialects is not a one-time task for a single individual; it's an ongoing process that requires periodic re-evaluation and updates. Forty to seventy years have passed since scholars from the Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences actively conducted research expeditions between the 1950s and 1980s. Since then, continuous population migration has occurred. It's also important to note that very few people today maintain their dialects in their pure form. Within the scope of the "Research on Mongolian Language Dialects" foundational research project, carried out by the Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences from 2022 to 2024, I have summarized and presented the findings of my research on the current state of the khalkha dialect. Within the Khalkha dialect of Mongolian there are four recognized subdialects. These subdialects share common territory and ethnic origin, but are distinguished by their specific phonological, morphological, and lexical features. Nevertheless, they retain the overall characteristics of the Khalkha dialect and the general features of the Mongolic language as a whole, and they conform to the norms of the standard written language. In addition, there exists an intercurrent Buriad–Khalkha dialect. This variety developed among communities where one group was ethnically Khalkha and the other consisted of Mongolized Evenki (Khamnigan). Having coexisted in the same locality for an extended period, the latter assimilated to the speech, customs, and material culture of the Buriad, while at the same time adopting features from both dialects. Furthermore, eleven branches of subdialects are identified. These generally correspond to subdivisions within the ethnic community based on clan, locality, or historical background, and they exhibit relatively minor but distinctive linguistic traits. However, they still preserve the overall characteristics of central, western, and eastern Khalkha, as well as the intermediate Buriad-Khalkha dialect, while maintaining the shared features of the Khalkha dialect area as a whole.

Key words: Dialect, Subdialect, Intercurrent Subdialects, Branch of Subdialect; Khalkha Dialect, Ulaanbaatar Subdialect, Central Khalkha, Western Khalkha, Eastern Khalkha, Khalkha-Buryat Intercurrent Subdialects

1. Удиртгал

Финландын монголч эрдэмтэн Г.И.Рамстедтийн “Халх-монгол хэлний үйл үгийн ялгал, бүтэц” (1903)¹ “Монгол бичгийн хэл ба халх-Өргөөгийн аман аялгууг харьцуулсан авиа зүй” (1903, 1908)², Английн эрдэмтэн Невилл Ж.Ваймантын “Монгол хэлний зүй: Халх-монголыг буриад, халимаг, ордосын зарим эшлэлтэйгээр тоймлох нь” (1926)³, Зөвлөлт Холбоот Улсын монголч эрдэмтэн Б.Я.Владимирцовын “Монгол бичгийн хэл ба халх аман аялгууны харьцуулсан хэл зүй” (1929)⁴, Н.Н.Поппегийн “Халх-монгол хэлний байгуулал” (1936)⁵ хэмээх

¹ G.J.Ramstedt. “Über die Konjugation des Khalkha-Mongolischen”, {= Memoires de la Societe Finno-Ougrienne, XIX}, Helsingfors, 1902, CV+128

² G.J.Ramstedt. “Das Schriftmongolische und die Urganmundart phonetisch verglichen, JSFOu., 21, 1903, 3-55
Г.И.Рамстедт. “Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора”. СанктПетербург, 1908, VIII+63 стр.

Г.И.Рамстедт. “Монгол бичгийн хэл ба Өргөөгийн халх аман аялгууны харьцуулсан авиа зүй”. Орчуулсан Г.Лувсанцэрэн. “Хэл зохиол” УБ., 1967, 4:2, 117-169.

³ Neville J. Whymant. “A Mongolian Grammar. Outlining the Khalkha Mongolian with Notes on the Buriat, Kalmuck, and Ordoss Monolian”. London, 1926. viii + 74 pp.

⁴ Б.Я.Владимирцов. “Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия” (Введение и фонетика). Ленинград, 1929

алдарт бүтээлүүд дараалан хэвлэгдсэнээр халх аялгууны судалгаа эхэлжээ. Мөн Унгарын судлаач Баалинт Габор 1871-1873 онд монгол хэлийг, ялангуяа халимаг болон халх монгол хэлийг дэлгэрэнгүй судалж байсныг хожим Бирталан Агнэш эмхэтгэн [Дорнод монгол /халх/ эх бичвэрүүд], [Дорнод /зүүн/ ба өрнөд /баруун/ монгол хэлний латинчилсан хэл зүй. Хоёр аялгууны хялбаршуулсан унших бичиг] гэх мэт цувралаар хэвлүүлжээ (Бирталан Агнэш, 2016: 17).

Түүнээс хойш Г.Д.Санжеев, В.М.Наделяев, Д.Стюарт, М.Халтод, Д.А.Троксел, А.Рона-Таш, Б.Ринчен, Г.Абэмацу, Л.Бэшэ, М.Шинэхүү, Ш.Лувсанвандан, А.Лувсандэндэв, Т.Пагва, Э.Вандуй, Ж.Цолоо, Ш.Барайшир, Ц.Баярсүрэн, Ж.Төмөрцэрэн, Д.Төмөртоогоо, Б.Амаржаргал, А.Лувсандэндэв, Ж.Роозон, Ж.Санжаа, Я.Баатар, Ш.Шиотани, Д.Туяа, Д.Туул, С.Доржсүрэн, Одончимэг, Ц.Сувд, Л.Болормаа, Х.Лхагвабаяр, С.Булгантамир, Ц.Батдорж, Г.Батзаяа гэх мэт олон эрдэмтэн судлаач халх аялгууны тухай судалж, судалгааны нэг сэдэвт бүтээл хэвлүүлж, эрдэм шинжилгээний өгүүлүүд нийтлүүлжээ (Батзаяа нар, 2024: 38-49).

Судар бичгийн хүрээлэнгийн дуун ухааны тасгаас эхлээд Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид наяд жилийн турш бүрдүүлсэн нутгийн аялгууны арвин хэрэглэгдэхүүнийг эмхэтгэн “БНМАУ-ын нутгийн аялгууны толь”-ийг 3 ботиор хэвлүүлсний I нь Б.Амаржаргал нарын найруулсан “Халх аялгууны толь бичиг” (1988)⁶ юм.

Ийнхүү монгол хэлний халх аялгууг Монголын болон монголч эрдэмтэн судлаачид 100 гаруй жил судлахдаа түүний бүтцэн дэх аман аялгуу, салбар аман аялгуунуудыг өөр өөрөөр нэрлэж, өөр өөрөөр ангилж иржээ. Түүнчлэн монгол хэл, аялгуунуудыг олон янзаар ангилан хуваасан нь хүн амын угсаа гарал, түүхэн замнал, нүүдэл суурьшил, улс орны хил хязгаар, улс төрийн үзэл баримтлал, нутгийн аялгууны хөгжил хувьсал, нутгийн аялгуу судлалын ухааны хөгжил гэх мэт хэлний ба хэлний бус олон хүчин зүйлтэй холбоотой юм. Түүнээс гадна аливаа хэл, ялангуяа амьд аман яриа тасралтгүй хувьсан хөгжиж байдаг учраас ойр зэргэлдээх бусад хэл, аялгуунаас нөлөөлөх, ижилсэх, ялгарах, явцуурах, өргөжих, хүн ам нь тухайн аялгуугаа хэрэглэхээ болих, мартах, сэргээх зэрэг хувиралт өөрчлөлт үргэлжилсээр байдаг. Иймээс хэл, аялгуу, түүний доторх аман болон салбар аман аялгууг ангилан хуваах явдал бол нэг удаа, нэг хүн хийгээд орхих ажил биш, тодорхой хугацааны давтамжтай, байнга хөгжүүлж, шинэчилж байх хэрэгтэй ажил юм.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид 1950-1980-аад онд шинжилгээний ангиудаар явж, нутгийн аялгуунуудыг идэвхтэй судалж байсан тэр үеэс даруй 40-70 жил өнгөрч, ард иргэд хөдөө орон нутгаас аймгийн төв, хот хүрээнд болон өөр өөр аймаг сумдын хооронд шилжин суурьших явдал тасралтгүй өрнөсөөр байна. Өдгөө бичиг үсэг мэдэхгүй, гэрийн ажилтай, орон нутгаасаа гарч, хот суурин газар их, бага хугацаагаар явж үзээгүй, хэвлэл мэдээллийн сувагтай харьцдаггүй буюу нутгийн аялгуугаа цэврээр хадгалж буй хүмүүс цөөрсөөр байгааг ч тэмдэглэх хэрэгтэй. Тиймээс бидний судалж буй нутгийн аялгуутнууд бол гол төлөв хоёр аялгуутан хүмүүс байдаг. Тэд Улаанбаатарын хүмүүстэй ярих юм уу албан ажлын үед стандарт монгол хэлний суурь аялгуугаар ярьж, харин нутаг орондоо өөрсдийн аялгуугаар ярьдаг болжээ.

Монгол хэл нь халх, ойрад, буриад гурван нутгийн аялгуутай. Бид энэхүү өгүүлэлдээ халх аялгуу өнөөдөр ямархуу байдалтай, хэчнээн аман аялгуунд ангилж болохуйц байгаа талаар өгүүлэхийг зорилоо.

⁵ Н.Н.Поппе. “Строй халха-монгольского языка”. Ленинград, 1936, 24 стр.

⁶ Б.Амаржаргал. “БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг (Халх аялгуу)”, УБ., УХГ., 1988, 718 тал.

2. Судалгааны арга зүй

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбараас 2021-2024 онд хэрэгжүүлсэн “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” сэдэвт суурь судалгааны төсөл⁷-ийн хамт олон монгол хэлний нутгийн аялгуутан, аман аялгуутан бүрийн, олонх салбар аман аялгуутны нутагт шинжилгээний ангиар явж, өнөөгийн байдлыг сурвалжлан судлав. Монгол хэлний халх аялгууг судлах ажлыг миний бие зонхилон гүйцэтгэсэн билээ.

Судалгааны явцад монгол хэлний нутгийн аялгууны хуваарилалтыг өнөөгийн байдлаар шинэчлэн тогтоох, ‘Монгол хэлний нутгийн аялгууны байршлын зураг’ шинээр хийх зайлшгүй шаардлагатай болох нь ажиглагдсан юм. Бид аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуугаар хэлэлцэгчидтэй биечлэн уулзаж ярилцан, өдөр тутмын энгийн яриа, жич аман зохиол, уран зохиол зэргээс жишээ баримт цуглуулан, тухайн аялгууны дуудлагыг IPA (International Phonetic Alphabet) – олон улсын авианы галигаар тэмдэглэж, утгыг кирилл бичгийн зөв бичих дүрэмд захируулан бичив.

Мөн аялгуу тус бүрийн төлөөллөөс аудио видео бичлэг хийх, тэмдэглэл хөглөх зэргээр ажиллаж, тэр бүхэндээ хэл шинжлэлийн үүднээс анализ шинжилгээ хийсэн юм. Нутгийн аялгууг дан ганцаар нь биш, тухайн аялгуутны угсаа гарал, түүхэн замнал, ахуй соёл, ёс заншлын хам хүрээнд нь авч үзэхийг эрхэмлэв. Тийм агуулга бүхий хорь гаруй видео бичлэг хийж, кирилл бичвэр, галиг үсгийн хадмалтай цахим хөмрөг үүсгэж, “МХНАС 2024” хэмээх Yutube суваг нээж, байршуулсны дотор тус өгүүлэлд дурдсан халх аялгууны 12 салбар аман аялгуу буй.

Бид тус судалгааныхаа суурь баримжаа болгож нутгийн аялгуу – аман аялгуу – салбар аман аялгууны тодорхойлолтыг академич Ш.Лувсанвандан болон бусад эрдэмтэн судлаачдын тодорхойлолтод тулгуурлан шинээр найруулан томьёолов. Үүнд:

А. Улс орны тодорхой нэгэн нутагт оршин суугаа, угсаа гарал, түүх, ёс заншил, ахуй соёл зэргээрээ нэгдмэл бүлэг хүмүүсийн ярилцдаг, тухайн хэлний салбарыг **нутгийн аялгуу** гэнэ. Нутгийн аялгуунууд өөр хоорондоо аман хэлний хүрээнд авиа зүй, хэл зүй, үгийн сангийн түвшинд ялгарах боловч тухайн хэлнийхээ нийтлэг шинжийг хадгалж, бичгийн хэлэнд захирагдана. Оросоор *диалект*, англи хэлээр *Dialect* гэнэ.

Б. Нутгийн аялгууны доторх буюу тухайн угсаатны доторх бүлгийн хүмүүсийн ярилцдаг хэл яриаг **аман аялгуу** гэнэ. Голдуу газар нутгийн байршил болон уг гарлаараа нэгдсэн байх бөгөөд авиа зүй, хэл зүй, үгийн сангийн хувьд тодорхой хэмжээгээр өөр өөрийн онцлогтой байх боловч тухайн нутгийн аялгууныхаа ерөнхий онцлогийг болон үндэстний хэлнийхээ нийтлэг шинжийг хадгалж, бичгийн хэлэндээ захирагдана. Оросоор *говор*, англи хэлээр *Subdialect* гэнэ.

В. Угсаа гарвалийн хувьд өөр угсаатан, үндэстнээс гаралтай нь тодорхой боловч нэгэн нутагт олон жил хамт суурьшсан аялгуутныхаа хэл яриа, зан заншил, ахуй соёлд ихээхэн адилсан бол **завсрын аман аялгуу** гэнэ. Завсрын аман аялгуу нь өөрийн уугуул аялгуутан болон оршин суугаа зонхилох аялгуутан хоёрын аль алиных нь шинжийг авиа зүй, хэл зүй, үгийн сангийн түвшинд тусгасан байх боловч зонхилох аялгуутныхаа хэлний нийтлэг шинжийг түлхүү тусгаж, нийтээр мөрдөж буй бичгийн хэлэндээ захирагддаг байна. Оросоор *промежуточный говор*, англи хэлээр *Intercurrent Subdialect* хэмээн орчуулж болох юм.

Г. Аман аялгууны доторх өөр хоорондоо бага хэмжээгээр ялгарах бүлэг хүмүүсийн ярилцдаг хэл яриаг **салбар аман аялгуу** гэнэ. Голдуу угсаатны доторх овог, нутаг ус, түүхэн замналаараа нэгэн бүлэг болж, авиа зүй, хэл зүй, үгийн сангийн хувьд тодорхой, цөөн онцлогтой боловч тухайн аман аялгуу, нутгийн аялгууныхаа ерөнхий онцлогийг болон үндэстний хэлнийхээ нийтлэг шинжийг хадгалж, бичгийн хэлэндээ захирагдана. Оросоор *подговор* гэдэг, англи хэлээр *Branch of Subdialect* хэмээн орчуулж болох юм.

⁷ Г.Батзаяа, О.Самбуудорж, Д.Боролзой, С.Энхжаргал, М.Очирцэнд, Б.Лхагважав, Х.Лхагвабаяр, Б.Отгончимэг, Г.Дэлгэрмаа, Г.Ариун-Онон. “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа”. УБ., 2025

3. Халх аялгуутан ба халх аялгууны тухай тойм

Халхын түүхийг судалж, “Халх товчоон” хэмээх бүтээл туурвисан түүхч Д.Гонгор халхчуудын удам угсаа, түүхэн замналыг дараах байдлаар бичжээ: *Төв Азийн өндөрлөгт оршин амьдарч байсан эртний олон угсаатан овог аймаг дотроос Хүннү бол монгол угсаатны өвөг гэж анх Оросын эрдэмтэн Н.Бичурин санал дэвшүүлжээ. Хүннү нарын түүх МЭӨ III зуунаас эхлэн Сяньби, Тоба зэрэг төр улсын түүхээр уламжилж, МЭ VI-VIII зуунд Түрэг аймгуудад дарагдан, Хиян, Нукус хэмээх хоёр жижиц аймаг үлдээд, Эргүнэ хон хэмээх газарт 400-аад жил амьдарч, өнөржин олишрсны эцэст тэндээсээ нүүдэллэн гарч, уугуул нутаг Онон, Хэрлэн, Туул гурван голын эхэн, Бурхан халдун уулын орчимд очиж суурьшжээ. Дарлигин хэмээх ерөнхий нэрээр түүхэнд тэмдэглэгдсэн монгол овогтнуудын дотроос Хиян овгийнхон илүү хүчирхэг байж, дараа нь Алунгуа хатны бага гурван хүүгийн удмаас үргэлжилсэн Нирун аймаг, тэр дундаа Бодончар мунхагийн удам Боржигин овгийн түүх үргэлжилсээр, XII-XIII зуун гэхэд монгол угсаатанд төвлөсөн Хамаг Монгол, улмаар Их Монгол улсыг байгуулжээ. Алунгуагаас Хабул хаан хүртэлх үеийг нийтэд нь Нирун хияд, Есүхэй баатар, Чингис хаан тэргүүтэн, түүний хөвгүүдийн удам угсааг Хияд боржигин гэдэг байжээ. Түүнээс хойш ч халхын ноёд өөрсдийгөө Боржигин овогт, Хияд ястан гэж тооцдог байсан (Гонгор, [1970] 2015: 58-87).*

‘Халх’ хэмээх үг ‘Монголын нууц товчоон’-д (175, 176, 191, 192, 208-р зүйл) газар усны нэрээр цөөн тохиолддог, ‘Эртний Монголын үндэсний их шар тууж’, ‘Мянган хигээст бичиг’ гэх мэт дурсгалт бичгүүдээс XIII зуунд язгуурын монголчуудын дотор халх нэртэй аймаг байсан, Юан улсын дараа Зүүн Монголын зургаан түмний дотор Халх түмэн байж, түүнээс хойш өдгөө хүртэл уг нэрээрээ явсаар иржээ. Гурван голын язгуурын монголчууд тэргүүлэн, халх нэртэй болсон нь тэдний нутаг ус монгол орны төв хэсгийг эзэлж байрласнаараа ч, хүн ам нь монгол туургатны уугуул иргэн болох язгуур гарлаараа ч, монгол угсаатан, үндэстнийг бүрэлдүүлж бусад олон монголчуудыг нэгтгэж явсны хувиар ч, монгол түүхийн үүднээс үзвэл XIII зууны үеэс түүхийн тавцанд товойн гарсан язгуурын монгол аймгуудаар бүрэлдсэн Хамаг Монгол улс, түүний байр суурин дээр үүсэж мандсан Монголын үндэс язгуурыг шууд залгамжлан хадгалж явсны хувиар ч, нийт монгол угсаатандаа халх түшиг нь болж байсантай холбоотой гэж үзэж болно (Гонгор, [1970] 2015: 193).

Хожим 1680-аад оны үеэс манж нарын нөлөөгөөр халх, ойрадын харилцаа хурцдаж, улмаар халхчууд хоорондоо зөрчилдөх болсноос Халхын хүчин суларч, 1691 онд Манжид дагаар орсноос хойш халхчуудыг дөчин есөн хошуунд хуваасан түүхтэй (Чулуун нар, 2016:70-91). Тийнхүү халхчууд Манжийн эрхшээлд 220 жил болсны дараа 1911 онд Богд хаант автономит Монгол улсыг байгуулсан билээ.

“Халх” хэмээх нэр нь ‘халхавч’ гэсэн утгатай хэмээн олонх судлаач үздэг байна. Монголын түүхийн алдартай түүхэн сурвалж бичгийн нэгэн болох ‘Эртний Монголын үндэсний хаадын их шар тууж’-д халх түмний талаар “Qangyai qan-dur sayuju qarin irekü-yin qarayul boluysan qalayun amin-dur tüsig boluysan qalq-a tümen” (Шастина, 1957: 96) хэмээснийг онцлон дурдвал зохино. Аялгуу судлаач Э.Вандуй “Халх аялгуу” нэг сэдэвт зохиолдоо: “Эрт цагаас халхчууд Монгол улсынхаа төв нутгийг эзэгнэн сууж, монгол төрийн хайгуул халхавч, түшиг тулгуур болж ирсэн” (Вандуй, 1966:6) хэмээн дурдсан нь дээрх санааг баталсан шинжтэй юм.

Өдгөө халхчууд Монгол Улсынхаа нийслэл хотод болон 21 аймагт тархан суудаг, хүн амынхаа тоогоор хамгийн олон. “Халх аялгуу нь нийгэм соёлын түүхэн онцлог болон туулж өнгөрүүлсэн хэлний хөгжлийн замналаараа бусад аялгуунаас нэлээд ахиж, үлгэр жишээ болохуйц аялгуу болж чадсан. Халх аялгуу нэгдмэл шинжтэй бөгөөд монгол хэлний олон нутгийн аялгуунд зууч болж, аялгуунуудын өөр хоорондоо ойлголцох хэрэглүүр болон үйлчилсээр иржээ” (Санжаа нар, [1993, 2010] 2018: 25-26). Монгол улсын 2020 оны хүн амын дэлгэрэнгүй тооллогоор халх аялгуутан 2659985 хүн байгаа бөгөөд энэ нь Монгол улсын хүн амын 83,8%-ийг эзэлж байна. Мөн дарьганга, үзэмчин, харчин, сартуул, элжигин болон завсрын, халхажсан аялгууг нэгтгэвэл 2705793 хүн (85,25%) байна. Халхчууд нь 1990-ээд

оноос хойш гадаад улс оронд ажиллаж, суралцаж, оршин сууж буй 100 гаруй мянган хүнийг⁸ эс тооцвол үндсэндээ Монгол Улсдаа төвлөрсөн байдаг.

Жич: 1900-аад оны эхээр Жаа лам буюу Дамбийжанцан ламыг дагаж БНХАУ-ын Ганьсу мужид нүүж очсон халхчууд, бас хувьсгалын үеэр тэдэн дээр нэмэгдэж баруун халхчуудаас нүүж очсон айл өрхүүд байсан гэдэг. Тэдний үр хойчис өдгөө ӨМӨЗО-ы Алшаа аймгийн Алшаа баруун хошууны Алтанцог, Нүүргэй, Алтан-Овоо сум, Алшаа зүүн хошууны Ингэн, Өлзийт сум, Эзнээ хошууны зарим сум, мөн Ганьсу мужийн Жан-е хотод тархан суурьшсан нийт арван мянга хүрэхгүй халх хүмүүс байдаг. Тэд хятад хэлээр ярихаас гадна нутаг орондоо халх аялгуугаараа ярьдаг. Гэхдээ өдгөө хэл аялгууны хуваарилалтад нэгэнт өмнөд монгол хэлний өвөр монгол аялгууны алшаа-эзнээ аман аялгуунд харьяалагдаж байна. Тэдний хэл яриаг Эрдэнэтана (2013, 2014), Хянган, Ли Мин (2013) нарын өвөр монгол эрдэмтэн судлаачид судалж, өгүүлэл нийтлүүлсэн байдаг (Батзаяа нар, 2024: 45-46). Өөр ийнхүү халхчууд бөөнөөр суурьшсан газар үгүй тул бид үүнийг энд дурдаж орхиод, харин энэхүү өгүүлэлдээ монгол хэлний (Монгол Улсын) халх аялгууны тухай өгүүлэх болно.

Монгол Улс дахь халх нутгийн аялгууны дотор дараах таван аман аялгуу, 12 салбар аман аялгуу байна.

3.1. Улаанбаатарын аман аялгуу

‘Улаанбаатарын аман аялгуу’ гэсэн ойлголт бий болоод удаагүй ч гэсэн ийм нийтлэг шинжтэй хэл аялгуу үүсэн бүрэлдээд олон жил болжээ. Бүр XVIII-XIX зууны үеэс “Их Хүрээ”, “Да Хүрээ”, “Нийслэл Хүрээ”, “Богдын Хүрээ” гэх мэт олон нэршлээр алдаршсан суурин амьдралын шинэ хэвшил, өвөрмөц соёл, донж маяг бүрэлдэн бий болсон бөгөөд тэр бүхэн нь Хүрээнийхний хэл аялгуунд тусгалаа олсон нь мэдээж. Харин түүнийг ажиглан судалсан нь нэн хожим юм.

Түүх сөхвөл 1639 онд анх Өргөө хот байгуулагдсан үеэс⁹ хойших 380 гаруй жилийн хугацаа монгол хүний амьдралын тав, түүнээс ч олон үеийг¹⁰ өнгөрөөжээ. Тийнхүү Улаанбаатарын уугуул иргэд нь 400 шахам жилийн өмнөөс энд суурьшиж, таван үе дамжихдаа өөрийн гэсэн хэл аялгууны нийтлэг шинжийг бүрдүүлсэн байна. Нийслэлчүүдийн хэл яриа нь нэг талаар тухайн хотын оршин суугчдын өдөр тутмын хэрэглээний хэл боловч нөгөө талаар, улс орны өнцөг булан бүрээс шилжин ирэгч олон аялгуутны үг яриагаар байнга баяжиж байдаг тул монгол хэлний хамгийн нийтлэг шинжийг агуулж байдаг. Улаанбаатар хот нь зам харилцааны зангилаа, сургууль, соёлын төвлөрөл, чөлөөт нийгмийн харилцаа зэрэг олон хүчин зүйлийн улмаас шилжин суурьшигчдаас гадна урт, богино хугацаагаар оршин суугчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байна. 2024 оны байдлаар Улаанбаатарын хүн ам 1768151-д хүрсэн¹¹ нь Монгол Улсын нийт хүн ам (3544835)-ын 49.88%-ийг буюу хагасыг эзэлж байна. Улаанбаатар хотод төрж өссөн, сурч хүмүүжсэн, насаараа ажиллаж амьдарсан бүхэн чухамдаа Улаанбаатарын аман аялгуутан юм. Улаанбаатарын аман аялгуу нь халхаас гадна халхажсан ойрад, буриад аялгуунаас бүрддэг бөгөөд тэр нь төв халхын аман аялгуунаас ч бага зэрэг ялгаатай.

Анх монголч эрдэмтэн Г.И.Рамстедт ‘Монгол бичгийн хэл ба халх-Өргөөгийн аман аялгууны харьцуулсан авиа зүй’ ([1903], 1908) хэмээх бүтээлдээ Өргөө хотын халхчуудын хэл ярианд суурилсан халх аялгууны тухай бичиж, түүнийгээ ‘говор’ хэмээн нэрлэжээ. Дараа нь Б.Я.Владимирцов “Гадаад монгол тусгай улс болсон тэр цагаас халх аялгууны нэр хүнд улам

⁸ 2024 оны байдлаар 106534 хүн гадаадад оршин сууж байна (ikon.mn). Гэхдээ тэдгээр иргэдийн угсаатны судалгаа тодорхойгүй.

⁹ 1639 онд Ширээт цагаан нуурын савд Өндөр гэгээнийг залж, орд өргөө босгосноор Улаанбаатар хотын анхны суурь байгуулагджээ. Түүнээс хойш хэд хэдэн удаа шилжин нүүж байгаад 1778 онд одоогийн энэ газар шилжин суурьшжээ.

¹⁰ 2024 оны байдлаар монгол хүний дундаж наслалт 71.8 байна (Үндэсний статистикийн хороо). Монгол хүмүүсийн айл өрх үүсгэж, үр хүүхэд төрүүлдэг дундаж нас нь ойролцоогоор 20-30 нас байдаг.

¹¹ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Үндэсний статистикийн хороо.

нэмэгдсэн нь мэдээж. Ийм нөхцөл шалтгаанаас буюу ялангуяа улс үндэстний хэл болсон нэр хүндийнхээ хувьд хуучнаасаа халин давж, монгол хэлний бусад ойролцоо аман аялгууг давамгайлж байна. Халх аялгуу ар монголын нийтийн хэл болох хандлагатай болж байгаа бөгөөд гэхдээ Өргөө-Улаанбаатар төвтэй халх хүрээний аман аялгуу ялан дэлгэрч байна” (1929: 49-50) гэж тэмдэглэжээ.

Монгол хэл шинжлэлийн бүтээлүүдэд “Утга зохиолын хэл нь тухайн ард түмний улс төр, соёл, шинжлэх ухааны бүх салбарт хэм тэгш үйлчилж байгаа дуун ухаан хэмээх хэл шинжлэлийн талаасаа боловсорч, харьцангуй тогтворжсон хэм хэмжээ бүхий хэл юм... Монголын орчин үеийн утга зохиолын хэлний суурь болсон аялгуу нь халх аялгуу юм” (Санжаа нар, [1993], [2010], 2018: 20, 25) гэх мэтээр тодорхойлж ирсэн боловч зөв дуудах зүй, зөв бичих зүйн хэм хэмжээг их төлөв Улаанбаатарын хэл ярианд тулгуурлан тогтоосон байдаг.

Сүүлийн үед Ц.Батдорж, Д.Заяабаатар нарын эрдэмтэд Улаанбаатарын хэл яриа (Ulaanbaatar speech)-г стандарт аялгуу (Standart Dialect) хэмээн тодорхойлж байна. Тухайлбал Ц.Батдорж “Түүхээс үзэхэд, тухайн нийгмийнхээ улс төр, эдийн засаг, соёл боловсролын тогтолцооны төв болж буй хотын хэл яриаг суурь аялгуу болгох нь түгээмэл байдаг. Тухайлбал, орос хэл Москвагийн, франц хэл Парисын, англи хэл Лондоны, чех хэл Прагийн, япон хэл Токиогийн, хятад хэд Бээжингийн аялгуунд суурилжээ” (Батзаяа нар, 2022: 27) гэсэн бол Д.Заяабаатар “Бид монгол бичгийн хэлний суурь аялгууг халх гэж нэрлэхээс илүү олон улсын жишгээр нийслэл буюу төвлөрсөн газраар нь Улаанбаатар аялгуу гэж хэвшүүлэх саналтай байна. Монгол бичгийн хэлний суурь аялгууг Улаанбаатар аялгуу гэж нэрлэх нь зарим талаар хэл аялгууны тогтолцоот үзэгдлийг угсаатны ээдрээт асуудал болгон хувиргаж хутгадаг байдлаас ч зайлсхийх давуу талтай. Улаанбаатар аялгууны зөв дуудах ёсны хэм хэмжээний гол шалгуур нь халх аялгууны дуудлагын тогтолцоо болно” (Пүрэвжав нар, 2022: 132-133) гэжээ.

Улаанбаатарынхны аман аялгууг өдгөө хүртэл төв халхын аман аялгуунд багтаасаар ирсэн боловч дараах нарийн ялгаа бий. Тухайлбал:

Авиа зүйн хувьд: Улаанбаатарынхан [xɔtʰ] – *хот*, [χatsʰər] – *хацар*, [ʧʰixər] – *чихэр*, [tsʰetsʰək] – *цэцэг*, [tʰɔs] – *мос*, [tʰaxtʰa:] – *тагтаа* гэх мэтээр хэлдэг бол төв халхад үгийн эхэнд тохиолдох амьсгалын түрэлттэй, дуугүй чанга [x/χ], [ʧʰ], [tsʰ], [tʰ] гийгүүлэгчүүдийг дэд үеийн эхэнд орсон чанга гийгүүлэгчээс ондоошуулж, амьсгалын түрэлтгүй болгон сулруулж [k/q], [ʧ], [ts], [t] гэж хэлэх нь түгээмэл байдаг. Мөн [tsarʧʰəm] – *зарчим*, [tsaŋʧʰəl] – *занишл*, [tsʰa:ʃ] – *цааши*, [susək] – *сүсэг*, [ʃæstər] – *шастир* гэх мэтээр Улаанбаатарынхан хэлж байхад төв халхчууд үгийн эхний шүд-түүшний [ts], [tsʰ], [s] гийгүүлэгчүүдийг дэд үед орсон түүш-тагнайн [ʧ], [ʧʰ], [ʃ] гийгүүлэгчүүдтэй ижилсүүлж ярьдаг. Мөн [pit] – *бид* гэдэг үгийг [pʲat] гэх мэтчилэн зарим үгийн гийгүүлэгчийг тагнайшуулж ярьдаг, Архангай аймгийн төв халхчууд заримдаа [namæ:k~manæ:k] – *намайг* гэж авиа тонгоруулж ярьдаг, Булган аймгийнхан [næmæ:k] – *намайг* гэж авиа ижилсүүлж ярьдаг. Тэгвэл Улаанбаатарынхан их төлөв тэгж ярьдаггүй, дээрх гийгүүлэгчүүдийг үндсэн өнгөөр нь хэлдэг, [pit] – *бид*, [namæ:k] – *намайг* гэж бичгийн хэлтэй адилхан хэлдэг.

Хэл зүйн хувьд: [awtərta:r] – *авдар дээр*, [ɔrəntɔ:r] – *орон дээр* гэж өмнөх үгтэйгээ эгшгээр зохицсон орших тийн ялгалын нөхцөл төв халх болон бусад аялгуунд үүсэн бүрэлдэж байгаа бол Улаанбаатарынхан [awtər te:r] – *авдар дээр*, [ɔrən te:r] – *орон дээр* гэх мэтчилэн [te:r] гэж өмнөх үгтэй нь зохицуулахгүйгээр ярьдаг. Эзэнд хамаатуулах нөхцөлийг төв халхчууд [mɔɛɔ:ŋ onɑ:t] – *морио унаад*, [æmtərɬ:χɑ:ŋ] – *амьдралынхаа* гэх мэтчилэн эцсийн [ŋ] гийгүүлэгчийг хасахгүйгээр хэлэх нь түгээмэл байхад Улаанбаатарынхан [mɔɛɔ: onɑ:t] – *морио унаад*, [æmtərɬ:χɑ:] – *амьдралынхаа* гэж хасаж хэлдэг.

Үгийн сангийн хувьд: шинэ үг хэллэг, харь хэлнээс орж ирж буй үг хэллэг, орчуулгын үг хэллэг, жич этгээд, бүдүүлэг үг хэллэг гээд олон зүйлийн үг хэллэг шинэ тутам бий болсоор байна. Харин монгол уламжлалт ахуй амьдрал, мал аж ахуйн болон газар тариалангийн холбогдолтой үг хэллэг ялангуяа хүүхэд залуусын ярианд хомсдож байгаа явдал байна.

Ийнхүү, Улаанбаатарын хүмүүс их төлөв кирилл бичгийн хэлтэйгээ маш ойрхон ярьдаг онцлогтой. Үүнд Улаанбаатар хотын хүн амын амьдралын хэвшил, ахуй орчин шууд нөлөөлсөн. Тэдний олонх нь мал аж ахуй, газар тариалангаас хол, хүүхэд болон өсвөр нас, улмаар залуу насандаа олон жил бүх шатны боловсролын байгууллагаар дамжин хүмүүжиж, сургууль төгссөнийхөө дараа ч ямар нэг албан байгууллагад ажиллаж амьдрахдаа өдөр тутам бичгийн хэлтэй ойр дөт, ялангуяа өнөө үед хэвлэл мэдээллийн янз бүрийн сувгуудтай бараг насан турш ойр дөт амьдарч байна.

Гэхдээ Улаанбаатарын хүмүүсийн хэл яриа кирилл бичгийн хэлтэй яг тохирдог гэж ойлгож болохгүй. Тийнхүү бичгийн хэлтэйгээ зуун хувь тохирдог хэл хаана ч байхгүй. Хамгийн энгийн жишээ дурдвал: *эмнэлэг, санаачилга, сурвалжилга, авлигал* зэргээр үг зүйн зарчмаар бичдэг үгсийг [emlək], [sana:tʃʰlɑq], [sorwəlʃʰlɑq], [æwəlɣɑl] гэх мэтээр бичгээсээ өөрөөр дууддаг, *та-таа, би-бий, бэлэг-билиг-бэлгэ, төвд-төвөд, ойрд-ойрад* гэх мэтээр утга ялгах ба түүхэн уламжлалын зарчмаар бичдэг үгсийг [tʰa:], [pi:], [pelək~pələk], [tʰəwt], [œ:rt] гэж тус тус адилхан дууддаг зэргээр бичгийн хэл, аман яриа хоёр заавал ялгардаг юм.

Ийнхүү орчин цагийн монгол хэлний халх аялгуун дотор газар нутгийн байршил суугуул нутгаараа нэгдсэн ‘Улаанбаатарын аман аялгуу’ хэмээх нэгэн ангилал үүсэн бүрэлдсэн бөгөөд тэр нь монгол хэлний *суурь аялгуу (Standard Dialect)* болж байна.

3.2. Төв халх аман аялгуу

Халх аялгуу нь дотроо таван аман аялгуутайгаас төв халх аман аялгуу нь төв халх, өвөрхангайн халх, говийн халх гурван салбар аман аялгуутай.

3.2.1. Төв халх салбар аман аялгуу

Баянхонгор, Орхон аймгийн нийт хүн ам, Төв, Архангай, Өвөрхангай, Булган аймгийн олонх сум, Сэлэнгэ аймгийн хүн амын талаас илүү хувь нь төв халхаар ярьдаг. Төв халх нь олон шинжээр буриад, ойрад аялгуунаас, мөн цөөвтөр шинжээр баруун халх, зүүн халх аман аялгуунаас, цөөн тодорхой шинжээр Улаанбаатарын аман аялгуу, говийн халх, өвөрхангайн халх салбар аман аялгуунаас ялгарна. Төв халх нь:

Авиа зүйн хувьд: Үгийн тэргүүн үед [a], [ɔ], [o], [ø], [u], [e/i], [æ], [œ], [y] дан богино эгшиг, үгийн тэргүүн бус үед э (ä, ö, ё, ё, і, ъ, ѳ) балархай эгшиг, [a:], [ɔ:], [o:], [ø:], [u:], [i:], (i), [e:], [æ:], [œ:], [y:], [y:] дан урт эгшиг, [ja], [jæ], [jo], [jœ], [ju], [je/ji], [jø] хос богино эгшиг, [ja:], [jæ:], [jo:], [jœ:], [ju:], [je:], [jø:], [wa:], [wæ:], [oi], [ui] хос урт эгшгүүдтэй. Уруулын [p] (p^l), [p^h] (p^h), [m] (m^l), [w] (ф), шүд-түүшний [t], [t^h] (t), [ts], [ts^h] (ts), [s], [n], (n^l), [ɳ], (ɳ^h), (ɳ^l), түүш-тагнайн [ʃ], [ʃ^h] (ʃ), [ʃ], [r] (r), тагнайн [j], зөөлөн тагнайн [k] (k^l) (γ) (x), [x] (x^l) (k) (k^h) (x^k), [ŋ], хүүхэн хэлний [q] (в), (χ), [χ] (q^x), (x^q), төвөнхийн (h), ормол [f], [k^h] гийгүүлэгч авиалбар ба хувилбарууд байна¹². Нэг онцлог зүйл нь: Я.О.Свантессон нар “Халх аялгууны үгийн тэргүүн үед тохиолдох ‘u’ болон ‘э’ нь [i]-ийн чанартай нэгэн эгшигт хайлан шингэсэн байна” (2005: 22) гэснийг Ц.Батдорж, Э.Баярчимэг нар туршилт авиа зүйн судалгаагаар баталсан байдаг (Батзаяа нар, 2022: 59-60). Энэ үзэгдэл төв халх болон баруун халхад байна. Үгийн тэргүүн бус үеийн богино эгшгийн балархайшилт буриад хэл, аялгуунд хамгийн бага, говийн халхад түүний дараа, төв халх аялгууных түүнээс илүү балархайшсан, харин баруун халх, цаашилбал ойрад аялгуу, халимаг хэлнийх хамгийн их балархайшдаг. Төв халхчууд дээр дурдсанчлан [qəɣœ:] – *хорхой*, [qɑʃa:] – *хаашаа*, [tʃixəɣ] – *чихэр*, [tsats^hāk] – *цацаг*, [teftʃ^he:r] – *тэвчээр*, [taʃa:] – *ташаа* гэх мэтээр үгийн эхэнд тохиолдох дуугүй чанга гийгүүлэгчүүдийг дэд үеийн эхэнд орсон чанга гийгүүлэгчээс ондоошуулж, сулруулж хэлэх нь түгээмэл байдаг. Мөн [ʃæwʃa:ŋ] – *зарчим*, [ʃænʃəɳ] – *занишл*, [ʃ^ha:ʃ~ʃ^hæ:ʃ] – *цааши*, [ʃuʃək] – *сүсэг*, [ʃæʃtəɣ] – *шастир* гэх мэтээр үгийн эхний шүд-түүшний [ts], [ts^h], [s] гийгүүлэгчүүдийг дэд үед орсон түүш-тагнайн [ʃ], [ʃ^h], [ʃ] гийгүүлэгчүүдтэй ижилсүүлж ярьдаг.

¹² [авиалбар], (хувилбар)

Хэл зүйн хувьд: Мөн [awtərtə:r] – *авдар дээр*, [ərəntə:r] – *орон дээр* гэж өмнөх үгтэйгээ эгшгээр зохицсон орших тийн ялгалын нөхцөл төв халх болон бусад аялгуунд үүсэн бүрэлдэж байна. Эзэнд хамаатуулах нөхцөлийг төв халхчууд [mɒɐɐ:ŋ ɒnə:t] – *морио унаад*, [æmtəɐh:χa:ŋ] – *амьдралынхаа* гэх мэтчилэн эцсийн [ŋ] гийгүүлэгчийг хасахгүйгээр (-*ban/-ben*) хэлэх нь түгээмэл байдаг.

Төв халх аялгууг саяхан хүртэл монголын утга зохиолын хэлний суурь аялгуу гэж үзэж ирсэн бөгөөд монгол хэл шинжлэлийн бүтээлүүд үндсэндээ төв халх аялгуунд түшиглэсэн байдаг. Гэхдээ бусад нутгийн болон аман, салбар аман аялгуунаас ялгаж, төв халх аялгууг нутгийн аялгуу судлалын үүднээс судлах ажлыг 1968 онд Ж.Цолоо ахлагчтай анги, 1972 онд Ж.Цолоо нарын судлаачид Архангай аймгийн нутгаар явж, гүйцэтгэжээ.

3.2.2. Өвөрхангайн халх салбар аман аялгуу

Өвөрхангайн халх нь монгол хэлний халх аялгууны төв халх аман аялгууны нэг салбар аман аялгуу юм. Өвөрхангай аймгийн Уянга, Бат-Өлзий, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт сумын хүн ам өвөрхангайн халх салбар аман аялгуугаар ярьдаг. Тэдний хэл яриа нь тодорхой, цөөн онцлогтой. Үүнд:

Авиа зүйн хувьд: үе, үгийн эцэст [k/γ] гийгүүлэгчийг [q/ɸ]-аар хэлж, [tsʰaq] – *цаг*, [tʰarāq] – *тараг*, [nɒtʰɪ:ŋ χuŋ] – *нутгийн хүн*, [tsɒɐ:ŋ tewtʰɐɐ] – *зургийн дэвтэр* гэх мэтчилэн хэлдэг. Эсрэгээр, [ajək] – *аяга* гэх мэтчилэн цөөн үгэнд [q/ɸ] гийгүүлэгчийг [k/γ]-аар хэлдэг. Өгүүлэгч тодорхой баймж утга илэрхийлэхдээ урт эгшгийг зориуд сунган, дунд нь түр зогсосхийж [χuɐ:γe-e:ɪ so:n] – *хүлээгээд л сууна* гэх мэтчилэн хэлдэг. Мөн *суу-а* гэх мэт зарим үг төв халхад [soq] гэж урт эгшиггүй байхад өвөрхангайн халхад [so:] гэж урт эгшигтэй, төв халхад [ta:wo:] – *даавуу* гэдэг үгийг [ta:w] – *даавуу* гэж эцсийн эгшгийг гээж хэлдэг.

Хэл зүйн хувьд: олон тоот нэр үг бүтээх -*ынхан/-ийнхэн*, -*ыхан/-ийхэн* гэдэг нийлмэл бүтээврийг [manæχiŋ] – *манайхан*, [χɒtʰi:χiŋ] – *хотынхон* гэх мэтээр ямар ч үгэнд хүүхэн хэлний [χ] гийгүүлэгчээр хэлэхгүй, ямагт зөөлөн тагнайн [x] гийгүүлэгчээр хэлдэг. Мөн харьяалахын тийн ялгалын дараа гуравдугаар биед болон эзэнд хамаатуулах нөхцөл залгахдаа жийрэглэдэг гийгүүлэгчийг [qal qɒlɒmtʰi:ŋχe:] – *гал голомтынхоо*, [malɪ:ŋχe:] – *малынхаа*, [qal qɒlɒmtʰi:χiŋ] – *голомтынх нь*, [malɪ:χiŋ] – *малынх нь* гэх мэтээр ямар ч үгэнд зөөлөн тагнайн [x]-ээр хэлдэг. Үйл үгийн гуравдугаар биед зөвшин захирах -*г* нөхцөлийг өмнө нь урт эгшигтэйгээр *унтаг* [ɒntʰi:k] *хөөрхий*, *эцээхэн амраад аваг* [awɪ:k] гэх мэтээр хэлдэг. Халх аялгуунд тэмдэг нэрийн эхний задгай үеийг [w] гийгүүлэгчээр хааж, уг тэмдэг нэрийн үндсэнд утгуулан эрчимжүүлдгийг өвөрхангайн халх салбар аман аялгуунд [p] гийгүүлэгчээр хааж хэлдэг. Жишээ нь: [χар χаг, χор χо:гæ:, ɒр ɒ:ŋ] гэх мэт. Төв халхчууд [pu: mɐt] – *бүү мэд* гэж хэлдгийг [po: mɐt] гэж [o:] эгшгээр хэлдэг.

Үгийн сангийн хувьд: [a:ʃu:] – *аашгүй (ааш муутай, муухай зантай)*, [ɛtsʰe:χəŋ] – *эцээхэн (сайн, олигтой, зэгсэн)* гэх мэт цөөн өвөрмөц үг бий.

Өвөрхангайн халх салбар аман аялгууны тухай монгол хэлний нутгийн аялгуу, халх аялгууны судалгааны бүтээлүүдэд дурдагдсан боловч тусгайлсан судалгаа гэвэл: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 1964 онд У.Загдсүрэн ахлагчтай анги Өвөрхангай аймгаар хээрийн шинжилгээний ангийн судалгаа хийж, хэрэглэгдэхүүн цуглуулжээ. 1967 онд Ж.Төмөрцэрэн “Өвөрхангайн халх аман аялгууны зарим онцлогоос”¹³ хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсэн байдаг.

3.2.3. Говийн халх салбар аман аялгуу

Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн хүн ам говийн халх салбар аман аялгуугаар ярьдаг. Тэдний хэл яриа нь тодорхой, цөөн онцлогтой. Үүнд:

¹³ Ж.Төмөрцэрэн. Өвөрхангайн халх аман аялгууны зарим онцлогоос. “Монголын судлал” ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн сэтгүүл. УБ., 1967. Т.VI, F.16, 18-22; Ж.Төмөрцэрэн, “Монгол хэл шинжлэлийн өгүүлүүд”. УБ., 2023. 131-142.

Авиа зүйн хувьд: төв халх аялгууг бодвол аажуу тайван аялгатай, эгшгийн балархайшил багатай. Тиймээс төв халх шиг [e], [i] эгшгүүд өөр хоорондоо уусан нэгдээгүй, [tʰek] – *тэг*, [xempʁe] – *хэн бэ*, [xelsɛŋ] – *хэлсэн*, [iʃik] – *ишиг* гэх мэтээр тус бүрд нь тодорхой хэлдэг.

Хэл зүйн хувьд: *Явсаар байгаад* [jawa: wæ:ka:t] *ирлээ*, *явж байгаад* [jawʃɔka:t] *ирлээ* гэх мэтээр үйл үгийн үргэлжлэх *-саар/-соор/-сээр/-сөөр* нөхцөлийн гийгүүлэгчүүдийг гээж, [-a:/-ɔ:/-e:/-ø:] гэж хэлдэг, *байгаад* гэдэг үгийн эхний гийгүүлэгчийг сулруулах боловч гээдэггүй. *Явбал* [jawo:ŋ] *яв*, *ирвэл* [iru:ŋ] *ир* гэх мэтчилэн болзох *-бал/-бол/-бэл/-бөл* (*-вал/-вол/-вэл/-вөл*) нөхцөлийг [-o:ŋ/-u:ŋ] хувилбараар хэлдэг. Мөн бэлтгэх *-магц/-могц/-мэгц/-мөгц* нөхцөлийг *-сан дор* [-sən tɔr] гэдэг задлаг хэлбэрээр ([jawsən tɔr] – *явсан дор*) хэлдэг.

Үгийн сангийн хувьд: өдөр тутмын ярианы [ina:] – *энэ ээ* (*энэ хар аа*), [tʰira:] – *тэр ээ* (*тэр хар аа*), [møu:] – *мөгүү* (*том авдар*), [tʰawäʎa:] – *таваглаа* (*тэмээ, сургаж уядаг оосор*), [tʰiʎʎir] – *чигжир* (*мал, амьтны хоргол*), [xəwɾək] – *хөврөг* (*уяа*), [tʰa:to:] – *заадуу* (*заазуур*), [kiʃʎir] – *гичир* (*хөгнийн хоёр талын уяа*), [kəltʰrək] – *гөлтрөг* (*гэрийн халз*), [oxtsʰo:räq] – *угуурга* (*уяа оруулж уях нүх*) гэх мэт өвөрмөц үгс байна. Аяганы төрөл хэлбэрийг заадаг [ʃa:tsän] – *шаазан*, [tʰaxʃ] – *тагш*, [xompäq] – *хумбага*, [etəm] – *эдэм*, [pawwär] – *багвар*, [xot] – *хул*, [tʰo:la:] – *туулаа*, [xɔ:xo:ts] – *хоохууз* гэх мэт 10 орчим үг, модон хувингийн төрөл хэлбэрийг заадаг [avɾo:] – *агаруу*, [tʰɔɾx] – *торх*, [qan] – *ган*, [tsonts] – *зунз*, [xæftʰik] – *хавчиг*, [pesɾək] – *бэсрэг* гэх мэт 10-аад үг байна. Ингэж бага зэргийн ялгаа бүхий нэг төрлийн олон юмыг тус бүрд нь илэрхийлэх үгс тухайн нэг салбар аман аялгуунд байгаа нь монгол хэлний үгийн сангийн арвин баялгийг болоод монголчуудын сэтгэхүйн уран нарийн болохыг илэрхийлнэ.

Говийн халх салбар аман аялгууны тухай монгол хэлний нутгийн аялгуу, халх аялгууны судалгааны бүтээлүүдэд дурдагдсан боловч тусгайлсан судалгаа гэвэл: 1961 онд Х.Лувсанбалдан ахлагчтай анги Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн нутгаар, 1980 онд Ж.Цолоо, А.Лувсандэндэв, Л.Болд, Я.Баатар нар Дундговь аймгийн Дэрэн, Мандалговь зэрэг сумдаар, 1984 онд Г.Гантогтох нарын эрдэмтэд Дундговь, Дорноговь аймгийн нутгаар тус тус явж, хэрэглэгдэхүүн цуглуулжээ. Ж.Цолоо 1965 онд¹⁴ болон, 1967 онд¹⁵ өгүүлүүд бичиж нийтлүүлсэн байдаг.

3.3. Баруун халх аман аялгуу

Баруун халх аман аялгуу нь өрнөд халх, элжигин халх, сартуул гурван салбар аман аялгуутай.

3.3.1. Өрнөд халх салбар аман аялгуу

Өрнөд халх нь баруун халхын голлох салбар аман аялгуу бөгөөд Говь-Алтай аймгийн нийт, Завхан аймгийн зүүн сумд, Ховд аймгийн Ховд, Буянт сумдын хүн ам ярилцдаг. Ойрад аялгуутантай зэрэгцэн, холилдон суурьшсаны хувьд халх аялгууныхаа үндсэн онцлогийг хадгалахаас гадна ойрад аялгууны зарим шинж нөлөөлсөн онцлогтой. Тухайлбал:

Авиа зүйн хувьд: ö>[ø], ü>[u] эгшгүүдийг төв халхаас арай урдуур [ø], [y] гэж хэлдэг, [æ:] эгшгийг их төлөв [a:] эгшгээр хэлдэг, [æ:], [y:] эгшиг аль ч үед [ø:], [ɔ:], [u:], [o:] урт эгшигт шилжсэн, үгийн тэргүүн үед гийгүүлэгчийн дараа орсон *i* эгшиг дэд үеийн эгшигтэйгээ бүрэн ижилсээгүй, нармайн ба тагнайн (эм) эгшигт үгийн [x] гийгүүлэгчийг [kʰ]-ээр дууддаг зэрэг нь ойрад аялгууны нөлөө юм. Жишээ нь: [pa:ʃəŋ] – *байшин*, [maʎka:] – *малгай*, [ø.rəʎtsʰɔ:] – *ойролцоо*, [u:ʎəx] – *уйлах*, *činar* > [tʰinər] – *чанар*, [piɾo:] – *бяруу*, *mingʎan* > [minqə] – *мянга*, [kʰuŋ] – *хүн*, [umkʰi:] – *өмхий* гэх мэт. Үгийн эхний [i] эгшгийн өмнө [j] гийгүүлэгч нэмэгддэг үгс бий. Жишээ нь: [jinq] – *ингэ*, [jintu:] – *индүү*, [jirmək] – *ирмэг* гэх мэт.

¹⁴ Ж.Цолоо. Говийн халх аман аялгууны зарим онцлог. “БНМАУ-ын ШУА-ийн мэдээ” сэтгүүл. УБ., 1965. №2, 96-102.

¹⁵ Ж.Цолоо. Говийн халх аман аялгууны үгийн бүрэлдэхүүний зарим онцлог. “Монголын судлал” ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн сэтгүүл. УБ., 1967. Т.VI, F.17, 23-37.

Хэл зүйн хувьд: харьяалахын тийн ялгалын нөхцөлийг [-a:/-e:], чиглэхийн тийн ялгалын нөхцөлийг голдуу [a:t], хамтрахын тийн ялгалын нөхцөлийг [-tʰa:/-tʰɔ:/-tʰe:] гэж хэлдэг. Жишээ нь: [ɔrna: ta:wo:] – *орны даавуу*, [xөгө:ne: iɾ] – *хөрөөний ир*, [qɔla:t] – *голоод*, [aɬʰo:ɾtʰa:] – *алчууртай*, [tʰɔfʰtʰɔ:] – *товчтой* гэх мэт. Үйл үгийн *-магц/-могц/-мэгц/-мөгц* нөхцөлийг *-н гэмц* [-ŋ kemtʰɔ] хэмээх задлаг хэлбэрээр илэрхийлдэг. Жишээ нь: *Энэ бичгийг харан гэмц* [xагəŋ kemtʰɔ] *ойлгосон* гэх мэт. *Болохоор, тэгэхлээр* гэдгийг [pɔləxʰe:n tɛrək] – *болохтой нь зэрэг*, [tʰeʊxte:n tɛrək] – *тэгэхтэй нь зэрэг* гэж хэлэх нь түгээмэл.

1966 онд У.Загдсүрэн ахлагчтай анги Говь-Алтай, Баянхонгор, 1969 онд Э.Вандуй ахлагчтай анги Завхан аймаг, 1958 онд Г.Рэнчинсамбуу ахлагчтай анги Ховд аймгийн Буянт, Мянгад сумд, 1979 онд Ж.Цолоо нар Завхан аймгийн нутгаар тус тус явж, өрнөд халх аялгууны хэрэглэгдэхүүн цуглуулжээ. Ж.Цолоо 1970 онд “Халх аялгуу” хэмээх нэг сэдэвт бүтээлдээ “Баруун халхын аман аялгуу” бүлгийг¹⁶ бичиж, 1986 онд Ж.Санжаа¹⁷ 1992, 2015 онд Б.Амаржаргал¹⁸ өгүүллүүдээ тус тус нийтлүүлжээ.

3.3.2. Элжигин халх салбар аман аялгуу

Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сумын нийт хүн ам, Баруунтуруун сумын хүн амын хагас нь элжигин халхчууд юм.

Тэдний угсаа гарлын талаар судлаач Б. Амаржаргал “Элжигин халхчууд Хонгирад аймгаас гаралтай, тэд угаас монгол угсаатны аймаг” (2007: 72) гэсэн бөгөөд, эрт дээр цагаас олон газраар нүүдэллэсний улмаас өөр олон газар ч Элжигин овогтон бүртгэгдсэн байна. ‘Монголын нууц товчоо’-нд Элжигин овгийн тухай дурдаагүй ч Элжигидэй гэгч хүний нэр гардаг. ‘Батмөнх даян хаан отгон хүү Гэрсэндээ ар халхын 13 отгийг өмчлүүлж, түүнийг нас барсны дараа 1550 онд их хатан нь уг 13 отгийг долоон хөвгүүндээ өмч болгон хуваахдаа хоёрдугаар хөвгүүн Ноёнтойд Элжигин, Бэсүд хоёр отгийг хуваарилсан тухай ‘Эртний Монголын үндэсний хаадын их шар тууж’ цадигт тэмдэглэсэн байдаг. Энэ хоёр овог нь хожим халхын баруун гарын Засагт хан аймагт харьяалагдсан 7 хошуу болжээ. Дараа нь Манжийн хааны зарлигаар Ханхөхий нурууны орчимд нүүж суурьшсан бол 1931 онд Ханхөхий, Бадрах, Цагаанхайрхан гэсэн 3 сум болж, өдгөө түүний суурин дээр Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан сум байгуулагдсан байна.

Элжигин халхын нэрийн тухай ‘Эл-тегин’ гэсэн хоёр үг нийлж ‘Элжигин’ хэмээх угсаатны нэрийг үүсгэсэн ба *el-* эртний алтай хэлнүүдэд *элгэн садан, өөрийн талын* гэсэн утгатай, *ард түмэн аймгийн холбоо, төр улсын* гэсэн санааг илэрхийлдэг байна. *tegin-* эртний түрэг хэлэнд *хааны хүү болон хааны гэр бүл* гэсэн өргөмж нэр гэж судлаач Ш.Хадбаатар (2006: 11) тайлбарлажээ.

Аялгууны онцлог: Баруун халх аман аялгууны нийтлэг онцлогийг илэрхийлж, “халх болон ойрад аялгууны дундын шинжийг хадгалсан” (Лхагвабаяр, 2014: 132) байхаас гадна бас өөрийн гэсэн цөөн, тодорхой онцлогтой. Жишээлбэл: [jaɬqɑ:tʰæ:] – *ялгаатай*, [pɔ:lqɑ:t] – *буулгаад*, [saɬqʰo:] – *залхуу* гэх мэтээр үгийн дундах [q], [k], [χ>qʰ] гийгүүлэгчийг бусад аялгуунаас тод хэлдэг. [osəm] – *хусам*, [aɬʰɛɾ] – *хацар*, [ɔtʰ] – *хот*, [aɬʰəs] – *хавтас*, [æfʰɛk] – *хавчиг (хувин)* гэх мэтээр үгийн эхний чанга гийгүүлэгч сугардаг. *явж байгаа, сурч байгаа* гэх мэтээр хэлдэг үгсийг *явж яваа, сурч яваа* гэсэн нийлэмжээр хэлдэг. [sɛmɛ:] – *сэмээ (жижиг цонх)*, [pɔɬxæ:] – *булхай (мод чирдэг чарга)*, [ɕʰɔɬwɛɾ] – *өшиглөвөр (уутан хөнжил)*, [tʰɔɬɛk] – *цоглог (хүүхдийн модон өлгий)*, [tʰɛɾxɛŋ] – *торхон (гүнгэрваа)*, [pɛ:ŋ] – *бөөн (түүхий сүүний бяслаг)*, [ɕʰxru:t] – *өнхрүүл (зөөхийгөөр хийсэн хайлмаг)*, [ɕʰxru:f] – *өнхрүүш (сүүлний тосоор хийсэн хайлмаг)* гэх мэт өвөрмөц үгс байна.

¹⁶ Ж.Цолоо. Баруун халхын аман аялгуу. “Халх аялгуу”. УБ., 1970. 133-222.

¹⁷ Ж.Санжаа. Орчин цагийн монгол хэлний зарим гийгүүлэгч ‘j’ гийгүүлэгчтэй сэлгэх ёс ба баруун халхын аман аялгууны эм үгийн эхний j-ийн учир. “УБИС-ийн “Эрдэм шинжилгээ - заах аргын бичиг”. УБ., 1986, №1 (14), 124-130. “Авиа-авиалбар-их авиалбарын тогтолцоо” үгүүлэл, товхимлын эмхэтгэл, УБ., 2011. 29-35.

¹⁸ Б.Амаржаргал. Баруун халхын аман аялгууны үгсийн сангийн онцлогоос. “Монгол хэл шинжлэл” ШУА-ийн ХЗХ-ийн сэтгүүл. УБ., 1992, Т.I(XXIII), F.11, 86-91.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 1958 онд Г.Рэнчинсамбуу ахлагчтай анги, 1963, 1964 онд Э.Вандуй ахлагчтай анги, 1967 онд Э.Вандуй ахлагчтай анги, 1986 онд Ц.Баярсүрэн ахлагчтай анги элжигин халх аялгууны судалгаа хийж, хэрэглэгдэхүүн цуглуулсан байна. Хожим Х.Лхагвабаяр¹⁹, Б.Лхагважав²⁰ нар өгүүлэл нийтлүүлж, Х.Лхагвабаяр 2014 онд ‘Элжигин халх салбар аман аялгууны үгийн сангийн судалгаа’ сэдвээр хэл шинжлэлийн докторын зэрэг хамгаалжээ.

3.3.3. Сартуул салбар аман аялгуу

Сартуулчууд Завхан аймгийн Алдархаан, Дөрвөлжин, Ургамал, Завханмандал, Сантмаргац, Баянхайрхан, Сонгино, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Түдэвтэй сумд, Ховд аймгийн Чандмань сум, Увс аймгийн Завхан суманд тархан суурьшжээ.

Угсаа гарлын хувьд, Дорж Банзаров сартуулчуудыг “Хореизм, Шахын захиргаанд байсан түрэг гаралтай аймаг” (1955: 188) гэж дурдсан бол Г.Д.Санжеев “Чингис хааны үед Дундад Азиас олзолсон гар урчуудын удам” (1953: 7-8) хэмээн тэмдэглэжээ.

‘Сартуул’ гэдэг нэрийн хувьд, Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Сарт таван толгой хэмээх уулын нэрээс “сартуул” гэдэг нэр үүссэн гэж нутгийн иргэд ярьдаг. Харин судлаачид Дундад Азиас нүүдэллэн ирсэн гэдэг. Тухайлбал Дорж Банзаров “түрэг гаралтай Сарт гэдэг аймгийн нэр дээр ‘улс’, ‘гүрэн’ гэсэн утгатай -гүр гэсэн дагавар залгаж үүссэн үг. Монголчууд нэг үгэнд хоёр ‘р’ хэлдэггүй учир сартуул болжээ” (1955: 188) гэсэн тайлбар хийжээ. Хожим Ц.Дамдинсүрэн “Сартуул гэдэг үг бол хоёр үгээс бүтсэн бололтой. ‘Сарт’ гэж Дундад Азийн хүмүүсийг хэлдэг, ‘аул’ гэдэг нь манайхны айл гэсэнтэй төсөөтэй суурин тосгон, бүлэг хүмүүсийн нэр юм” (1957: 188) гэсэн байдаг.

Аялгууны онцлог: Завхан аймгийн сартуулчууд их төлөв халх аялгуунд шингэсэн бол Ховд аймгийн сартуулчууд баруун халх аман аялгууны шинжийг илэрхийлэхээс гадна өөрийн гэсэн цөөн боловч онцлогтой. Жишээ нь: *суγ-a*>[so:], *šay-a*>[ʃa:] гэх мэт халхын бусад аялгуунаас урт эгшигийн дуудлагаар зөрдөг үгс байна. Ойрад аялгуутай төстэй [uʎu:] – *илүү*, [puʎu:] – *битүү*, [ʃuɣu:ŋ] – *ширүүн* гэх мэтээр тэргүүн үеийн [i] эгшиг дэд үеийн уруулын урт [u:] эгшигтээ татагдан ижилсдэг онцлог сартуулд тохиолддог. Ойрад аялгуунд сүү гэдэг үгийг [ys] гэж авиа тонгоруулж хэлдэг бол сартуулд [usu:] гэж эгшиг нэмж хэлдэг. [pœɣx] – *бурхи*, [ʃʰɔlo:] – *чулуу*, [ʃʰɔxəm] – *чухам* гэх мэтээр уруулын эгшгүүдийг сольж ярьдаг. Элжигин халх шиг үгийн тэргүүн үеийн чанга гийгүүлэгч сугарсан [aʃʰəs] – *хавтас*, [æʃʰək] – *хавчиг (хувин)* гэх мэт, өрнөд халх шиг үгийн эхэнд [j] гийгүүлэгч нэмэгдсэн [jin] – *ингэ*, [jirmək] – *ирмэг* гэх мэт үг бий. Мөн [kʰimär] – *хярам*, [ʃœrwəs] – *шөрмөс*, [omʃəx] – *униших*, [sœn] – *шөнө*, [qatʰəxtəʃ] – *гачигдал* гэх мэт гийгүүлэгч тонгорсон, сэлгэсэн үгс бий. Мөн [ɔ:xœ] – *оо хө (найзаа хө)*, [ʃatʰ~ʃitʰ] – *шат (эмээлийн дэвс)*, [ʃaxəmnək] – *шахамнаг (ээдэм)*, [jœɣo:ʃ] – *ёруул (хожуул)* гэх мэт цөөн өвөрмөц үг байна.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 1963, 1969 онуудад Э.Вандуй ахлагчтай анги Завхан аймгийн, 1979 онд Ж.Цолоо, Д.Өлзийбаяр, Я.Баатар, С.Ганбаатар нар Завхан, Ховд аймгийн

¹⁹ Х.Лхагвабаяр. Элжигин халхын салбар аман аялгуу. “Монгол судлалын чуулган” МУБИС-ийн МоСС-ийн сэтгүүл, УБ., 2010, №8 (43).

Х.Лхагвабаяр. Э.Равдан багшийн тольд ороогүй Элжигиний газар усны нэрийн тухайд. “Монгол судлалын чуулган” МУБИС-ийн МоСС-ийн сэтгүүл, УБ., 2013, №15(50).

Х.Лхагвабаяр. ‘Элжигин’ хэмээх нэрийн утгыг тодруулах нь. “Угсаатан судлал”. УБ., 2022, Том XXX.

Х.Лхагвабаяр. Элжигин халхын салбар аман аялгууны үгийн сангийн онцлог. “Элжигин халхын түүх, шашин, өв соёл” Монголын Бурхан Шашны Төв Гандантэгчэнлин хийдийн “Шашин, өв соёл судлал” цуврал, УБ., 2023, XXII, 159-173.

Х.Лхагвабаяр. Элжигин халхын салбар аман аялгууны онцлог. “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” төслийн хүрээнд хийсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийн хураангуй. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. УБ., 2023. 54-55.

²⁰ Б.Лхагважав. Хэл зохиолын хүрээлэнгийн сан хөмрөг дэх элжигин халхаас цуглуулсан материалуудын тухай. “Элжигин халхын түүх, шашин, өв соёл” Монголын Бурхан Шашны Төв Гандантэгчэнлин хийдийн “Шашин, өв соёл судлал” цуврал XXII, УБ., 2023, 98-102.

сартуул салбар аман аялгууг тус тус судалж, хэрэглэгдэхүүн цуглуулжээ. Үүний үр дүнд 1964 онд Э.Вандуй²¹, 1987 онд Я.Баатар²² эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлжээ.

3.4. Зүүн халх аман аялгуу

Монгол хэлний халх аялгууны зүүн халх аман аялгуу нь дотроо дорнод халх, дарьганга, халхажсан өвөр монгол хэмээх гурван салбар аман аялгуутай.

3.4.1. Дорнод халх салбар аман аялгуу

Дорнод халх нь зүүн халхын голлох салбар аман аялгуу бөгөөд Хэнтий, Дорнод аймгийн хойд сумдаас бусад, Сүхбаатар аймгийн өмнөд сумдаас бусад сумдын хүн ам ярилцдаг. Хэлний шинжээр буриад аялгуутай зарим зүйлээр төстэй. Мөн төв халхаас ялгарах өөрийн онцлог шинжүүдтэй. Тухайлбал:

Аялгууны онцлог: Говийн халх болон дорнод халх салбар аман аялгуу нь халх аялгуун дотроо ярианы хурд харьцангуй удаан, эгшгийн балархайшил багатай бөгөөд эгшиг, гийгүүлэгч авиануудыг тод, өөр өөрийнх нь онцлогоор хэлдэг. Тиймээс төв халхынх шиг [e/i] эгшгүүдийг өөр хооронд нь уусгаж хэлэх зэрэг үзэгдэл байхгүй, [хeŋ] – *хэн*, [tʰeysɛŋ] – *тэгсэн*, [mettɛk] – *мэддэг* гэх мэтээр [e] эгшгийг тод хэлдэг. Харин [ʃowo:~ʃowo:] – *шувуу*, [ʃʰoχəm~ʃʰəχəm] – *чухам*, [sɔnto:~sɔnto:ɪ] – *сондуул* гэх мэтээр уруулын эгшгүүдийг сольж ярьдаг онцлог бий. Мөн [toɪ:] – *дугуй*, [dæri:] – *даруй* гэх мэтээр [oi~y:] эгшгийг [i:/i:]-ээр сольж дууддаг онцлог бий. Монгол бичгийн хэлэнд үеийн эцэст дэвсгэрлэн ордог байсан хамжих *d* гийгүүлэгчийг дорнод халхад шүргэх [s] гийгүүлэгчээр дууддаг нь уг гийгүүлэгч бүтэх аргын хувьд суларсан хэрэг юм. Жишээ нь: *ebedkii*>[əwsəχ] – *өвдөх*, *qabadqu*>[χawsəχ] – *хавдах*, *qadqaqu*>[χaskəχ] – *хатгах*, *ödxen*>[əsxən] – *өтгөн*, [ni:syəχ] – *нийтгэх* гэх мэт. Бас дорнод халхад [w]-ийг [m]-ээр сольж [tʰemən] – *тэвнэ*, [χətməŋ] – *ховор* гэх мэтээр, [s]-ийг [ts/tsʰ]-ээр сольж [pælo:ts] – *балус*, [oxʰbʰo:ɬəq] – *угсуурга* гэх мэтээр дууддаг авианы сэлгэлт, солигдол бий.

Судалгааны хувьд: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 1958 онд Унгарын монголч эрдэмтэн А.Рона-Ташийн оролцсон анги Сүхбаатар, Дорнод аймгийн, 1966 онд Д.Цэнд, Х.Лувсанбалдан, Э.Вандуй ахлагчтай ангиуд Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгийн дорнод халх аялгууг тус тус судалж, хэрэглэгдэхүүн цуглуулжээ. Харин 1940 онд Л.А.Амстердамская зүүн халх ардын аман зохиолыг галиглан хэвлүүлснээс өөр зүүн халх аман аялгуу ба дорнод халх салбар аман аялгууны тусгайлсан судалгааны бүтээл алга байна.

3.4.2. Дарьганга салбар аман аялгуу

Сүхбаатар аймгийн Халзан, Баяндэлгэр, Асгат, Дарьганга, Наран, Онгон, Уулбаян, Түвшинширээ, Халзан сумдын хүн ам дарьганга салбар аман аялгуугаар ярьдаг. Дарьганга гэдэг нь Дарь уул, Ганга нуурын нэр юм.

“БНМАУ-ын угсаатны зүй” гурван боть бүтээлийн “Халхын угсаатны зүй” тэргүүн ботид “Тэдгээр сүрэгчид нь халх, цахар, өөлд угсаатны бүлгүүдээс бүрдсэн бөгөөд... хожим ‘дарьганга ястан’ ч гэж үзэх болсон юм. Дарьгангын доторх цахар, өөлд нь халхжиж халх буюу нутгийн нэр Дарьгангаар овоглох болжээ” (Бадамхатан, 1987: 37) гэсэн байдаг бол эрдэмтэн А.Лувсандэндэв “Дарьгангын хүн амын гарал үүслийн тухайд бол судлаачид, ихэнх мэдээлэгчид ноёныг нь халхаас, албат ардыг нь цахар найман хошуунаас гаргасан гэдэг санал нэгтэй байдаг билээ. Гэтэл зарим нэг мэдээлэгч албат ардын нь ч хагас нь халх гаралтай гэдэг юм. Энэ мэдээллийг илүү үндэслэлтэй гэж үзэх тал байна” ([1957] 2007: 192) гэсэн бол Б.Бадма-Оюу “Манж улс ойрадыг дайлах их цэргийг Дарьгангын нутгаар дамжуулан Монголд оруулж байсан, тэдгээр цэргийн уналгын агт морьдыг байрлуулах газраар дарьгангыг

²¹ Э.Вандуй. Завханы сартуул ба түүний аман аялгуу. “Хэл зохиол” (Эрдэм шинжилгээний өгүүллүүд) ШУА-ийн хэвлэл, УБ., 1964, Т.17, 189-211.

²² Я.Баатар. Завханы сартуулын салбар аман аялгууны авиа зүйн зарим онцлогоос, “Хэл зохиол” (Эрдэм шинжилгээний өгүүллүүд) ШУА-ийн хэвлэл, УБ., 1987. 16:14, 137-142.

сонгосон, цаашилаад ойрадуудаас олзолсон хүн, мал сүргийг төвлөрүүлэх газар нь Дарьганга болж байжээ... Ялангуяа Чингис хаанаас хойш Толуй ноёны эзэмшилд байгаад, XVI зууны үед Батмөнх даян хааны захиргаанд халх, цахарын хамт зүүн гурван түмнийг бүрэлдүүлж байсан урианханчууд өдгөө дарьгангын бүрэлдэхүүнд бий... Мөн 1696 онд Галдан бошигт Манжийн цэрэгт цохигдон дарагдсанаас хойш Манж нар ойрадуудыг сарниулан тараах бодлого явуулж,... заримыг нь дарьгангад аваачин мал маллуулж суулгасан байна” (2007: 20, 28, 31) гэж нэлээд тодорхой тайлбарлажээ.

Авиа зүйн хувьд: зүүн халх аман аялгууны нийтлэг шинжийг хадгалахаас гадна бас өөрийн гэсэн онцлог шинжүүд бий. Тухайлбал: эр чанга богино, урт [ɪ], [i:] эгшгүүд бий гэж А.Лувсандэндэв тэмдэглэжээ ([1957] 2007: 142-143). Жишээ нь: [mɪk] – *янаг*, [ɪwtsʰo:] – *явцуу* гэх мэтээр хэлдэг байна. Ийнхүү халх аялгуунууд дотроос зөвхөн дарьгангад энэхүү эгшиг байгаа нь цахар аялгууны шинж юм. Мөн [tentu:~təntu:] – *дэндүү* гэх мэтээр уруулын эгшгүүдийг, *nabči>[ɬawɟʰ]* – *навч*, *nobsi>[ɬəw]* – *новш* гэх мэтээр дуутай гийгүүлэгчүүдийг сольж хэлдэг. Дарьгангад цахар аялгууных шиг [oɛ:], [ue:] хос эгшгүүд бий. Жишээ нь: [oɛ:ʰbāŋ] – *уйтгар*, [χoɛ:w] – *хуйв*, [qoɛ:lāq] – *гуйлга*, [patrāŋqoɛ:] – *бадрангуй*, [tsamɥe:] – *замгүй* гэх мэт. Эдгээр хос эгшиг нь зарим үгэнд [æ:], [i:] урт эгшиг болж хувирсан. Жишээ нь: [tokæ:] – *дугуй*, [toxtʰæ:] – *дугтуй*, [ontæ: sontæ:] – *ундуй сундуй*, [χantʰi:] – *ханцуй*, [teɥte:xi:] – *дэгдээхэй*, [erwe:xi:] – *эрвээхэй*, [ʰeli:] – *мэлээ* гэх мэт. Энэ нь монгол хэлний хос эгшгийн хөгжлийн нэгэн чухал зүй тогтлыг илтгэх баримт болж буйг А.Лувсандэндэв “нэг талаас монгол хэлний хос эгшгийн хоёрдугаар элемент нь урт удаан хөгжлийн явцад дийлж, хос эгшиг нь хэлний урдуурх урт эгшиг болж байгааг, нөгөө талаас хос эгшгийг уртаар дуудахад зөвхөн хоёрдугаар элемент нь уртаар дуудагддаг явдал монгол хэлний хос эгшгийн өгсөх хос эгшиг болохыг гэрчилж байна” (Лувсандэндэв, [1957] 2007: 148) гэж дүгнэсэн байна. Амьсгалын түрэлттэй, чанга гийгүүлэгчүүд дэд үе нь чанга гийгүүлэгчээр эхэлсэн үгийн эхэнд, тэргүүн үе нь урт эгшиг юм уу хамрын гийгүүлэгчгүй бол сул гийгүүлэгч болдог онцлог халх, цахар аялгуунд адилхан байдаг. Жишээ нь: [tɔs] – *тос*, [tewɟʰe:r] – *тэвчээр*, [tuɟmɛl] – *түшмэл*, [tsɛʰɛk] – *цэцэг*, [ʃatʰa:] – *чалчаа*, [kəwsɥər] – *хөвсгөр*, [kusɛl] – *хүсэл*, [qowtsʰās] – *хувцас*, [qotʰɛq] – *хутга* гэх мэт. Төв халхчууд бас ингэж хэлэх боловч суларсан, сулраагүй гийгүүлэгчүүдийг сэлгэж хэлдэг. Харин дарьгангад бараг сэлгэхгүй, ямагт суларсан хувилбараар нь ярьдаг. Чанга гийгүүлэгчүүдийн дотроос [s], [ʃ] хоёр халх аялгуунд суларч, өөрөөр хэлэгдэх тохиолдол бараг байхгүй бол дарьгангад [ts], [tʃ]-ээр хэлдэг тохиолдол бий. Жишээ нь: [tsɛʰɛl] – *сэтгэл*, [tsæxo:s] – *сахуус*, [tsælx] – *салхи*, [tsæxlāq] – *сахилга*, [tsux] – *сүх*, [tsartʰāsxi:x] – *сартасхийх*, [ʃatʰər] – *шатар* гэх мэт. Ийнхүү монгол хэлний чанга гийгүүлэгчүүд дурдсан орчинд суларч, сул гийгүүлэгчид шилждэг хувьсал дарьганга аялгуунд халхаас ч илүү тогтолцоотой байна. Дарьгангад [ukʰkʰɛɟ] – *үхэх (гэж)*, [ʰekʰkʰi:ŋ] – *тэгэхийн (тулд)* гэх мэтээр дараалан орсон хоёр гийгүүлэгчийг ижилсүүлж, уртаар хэлдэг нь цахартай адил. Халхад бол тэгж хэлдэггүй, нэгийг нь хасаж хэлдэг.

Хэл зүйн хувьд: Сонирхолтой бөгөөд тодорхой нэг онцлог бий. Үйл үгийн бүрмөсөн үйлдэх байдлын [-ʃʰəχ/-ʃʰəχ] бүтээврийн араас ямар нэг нөхцөл болон туслах үг залгах бүтээврийн заагт шүргэн хамжих [χ^q/χ^k] гийгүүлэгч хэлдэг. Жишээ нь: *Өөр асуучихаар* [aso:ʃʰiχ^qa:r] хүн байна уу?, *Сөдөтийн голын сөөвгөр хүү ийм том болчих нь* [pɔlʃʰiχ^qən] энэ үү?, *Та хэдийгээ төөрүүлчих вий дээ* [ʰə:ru:ʃʰiχ^ku:te:], *Цагаасаа хоцорчих вий* [χɔtsʰɔŋʃʰiχ^qo:] гэх мэт. Ийм өвөрмөц онцлог өвөр монголын цахар аман аялгуунд бас байдаг.

Үгийн сангийн хувьд, [o:ʃxə:] – *найзаа*, [aytāŋ] – *агдан (асар том)*, [aylo:ŋ] – *аглуун (1.өтгөн, аргуун, 2.махлаг, 3.чинээлэг)*, [ayto:rāχ] – *агдуурах (биеэ тоон бардамнах)*, [qaxo:ŋ] – *сахуун (исгэлэн)*, [marāŋ] – *маран (нэлээд том)*, [təsər] – *төсөр (удахгүй)*, [ʰəltər] – *төлдөр (тэр өдөр)*, [urxīŋ] – *үрхин (үргэлж)* гэх мэт өвөрмөц үгс бий.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 1955 онд А.Лувсандэндэв ахлагчтай анги, 1978 онд Х.Лувсанбалдан, Г.Гантогтох нарын судлаачид Сүхбаатар аймгийн нутгаар явж, дарьганга

аялгууны хэрэглэгдэхүүн цуглуулжээ. Түүний үр дүнд 1957 онд А.Лувсандэндэв²³ эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсэн бол А.Лувсандэндэвийн “Дариганга” хэмээх номыг 2007 онд Ц.Батдорж эмхэтгэн хэвлүүлжээ. Хожим 2010 онд Олон Улсын Улаанбаатарын Их сургуулийн монгол, солонгос эрдэмтэд Сүхбаатар аймгийн нутгаар явж, дарьганга аялгууны хэрэглэгдэхүүн цуглуулж, Г.Батзаяа²⁴ өгүүлэл нийтлүүлжээ. Мөн 2010 онд Дарьганга сумын уугуул С.Доржсүрэн гуай “Дарьганга нутгийн аялгуу” хэмээх, төв халх аялгуунаас авианы их, бага ялгамжтай болон төв халхад хэлдэггүй 408 толгой үг бүхий бэсрэг толь бичиг, 2012 онд С.Шархүү гуай “Дарьгангачуудын дунд өргөн хэрэглэгддэг зарим өвөрмөц хэлц үг” хэмээн нэрлэсэн, энгийн үг болон хэлц үг нийлсэн 300-аад толгой үг бүхий бэсрэг толь бичиг хэвлүүлсэн байна. 2015 онд Уулбаян сумын уугуул Ш.Чимэдцэеэ “Дарьганга хэл аялгууны мянгатын толь бичиг” хэвлүүлснийг 2025 онд Ш.Чимэдцэеэ, Г.Батзаяа нар нэмэн засварлаж, төв халхаас өөрөөр хэлдэг 1000 орчим үгийг кирилл үсэг, олон улсын авианы галигаар жагсааж, кирилл бичгийн зөв бичих дүрмийн дагуу тайлбарыг хадаж гаргав. Мөн “Дарьгангачуудын угсаа, түүхийн талаар товчхон”, Монгол хэлний зүүн халх аман аялгууны дарьганга салбар аман аялгуу” хэмээх судалгааны өгүүллүүд хавсаргажээ.

3.4.3 Халхажсан өвөр монгол салбар аман аялгуу

Үзэмчингүүд нь Монгол Улсын Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд төвлөрөн, Дорнод аймгийн Хэрлэн, Сэргэлэн, Баянтүмэн, Булган сумдад хэсэг бусгаар тархан суурьшиж байна. Мөн Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Булган, Баяндалай, Сэврээ, Гурвантэс, Ноён, Цогтцэций, Ханбогд сумд, Дундговь аймгийн Луус, Дэлгэрхаан, Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл, Алтанширээ зэрэг сумдад хэсэг бусгаар тархан суусан харчин хүмүүс бий.

Манжид эзлэгдсэнээсээ хойш ар, өвөр монголчууд тусгаар амьдрах түүх эхэлсэн бөгөөд 1945 онд үзэмчингүүд Монголд нүүдэллэн иржээ. Өмнөговь, Дундговьор нутаглан буй харчингуудын хувьд, анх 1715 онд манж хааны зарлигаар монгол нутагт ирж, Манжийн хааны өртөөний алба гүйцэтгэж байжээ. Харчин өртөө буусны сүүлд нутагт нь татан авах гэхэд тэд эргэж яваагүй гэдэг (Цолоо, [1982] 2011: 60-61). Дундговь аймгийн Луус сумын мэдээнд “1728 оны үед Чуулалт хаалганаас Улиастай хүртэл 64 өртөө байснаас 40 нь халхын нутагт байжээ. Энэ 40 өртөөний 20-ийг нь Өвөр Монголоос нүүлгэн ирүүлсэн харчин ардууд гүйцэтгэдэг байв. 13 өртөөний дунд нь байсан Луус өртөө сум болон үлдсэн ажээ” (mn.wikipedia.org/wiki/Луус_сум) хэмээн тэмдэглэсэн байна.

Аялгууны онцлог: “Үзэмчин аялгуунд монгол бичгийн хэлний *ᠵ*, *ᠳ* гийгүүлэгчийг хэлний урдуур *‘ж’*-ээр хэлдэг нь арын *а*, *и* хоёр эгшгийн дуудлагад нөлөөлж, урагшилсан *ä*, *e*, *ø* хувилбартай болгожээ. Жишээ нь: *džād* – *жаад*, *džāγas* – *загас*, *džätsig* – *цацаг*, *džer* – *жар*, *džextayā* – *чагтага*, *džödžān* – *зузаан*, *džəxal* – *чухал*, *džos* – *цус* гэх мэт. Харин *joki*, *joriγ* зэрэг үгийн *j* гийгүүлэгчийг *dž*-ээр хэлдэг боловч арын *о* эгшгийг урагшлуулж хэлдэггүй байна. Үгийн эхэн, дунд, адагт *и* эгшгийг *о/и* дундын *ø*-рхөг байдлаар дуудна. Жишээ нь: *ölān* – *улаан*, *öni* – *унь*, *otaγ* – *хутга*, *öt* – *уут*, *tšölö* – *чулуу*, *təja* – *туяа*, *manöl* – *мануул*. Туршилтаар *ø* нь *и, о*-г бодвол хэл өргөгдөж, *о*-г бодвол хэлний хөдөлгөөн агуу дунд байна. *é* нь *i*-ийн хугарал бүрэн болоогүй байна. Үгийн эхэн үед [xəɣax] – *хяргах*, [xəɣə~šəɣə] – *хөрөө*, [nəlχä] – *нялх*, [bərū] – *бяруу* гэнэ”²⁵ хэмээн Ж.Цолоо 1979 онд явсан шинжилгээний ангийн тайландаа тэмдэглэж байжээ. Энэхүү үзэмчин, харчин аялгууны уугуул шинж нь [ts], [tsʰ] хоёр гийгүүлэгчийг хэлдэггүй, байранд нь [tʃ], [tʃʰ] хэлдэг. Гэвч өдгөө халхажсан тул [ts~tʃ], [tsʰ~tʃʰ] сэлгэж ярьдаг болжээ. Жишээ нь: [tʃʰæ:~tsʰæ:] – *цай*, [tʃʰetʃʰək~tsʰetʃʰək] – *цэцэг*, [qatʃər~qatsər] – *газар* гэх мэт.

²³ А.Лувсандэндэв. Дариганга аялгууны авиан зүйг судалсан туршлагаас. “Шинжлэх ухааны хүрээлэнгийн бүтээл” (Нийгмийн ухааны анги), УБ., 1957, №2, 49-65; “Монголын үндэстний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь”, (эмхэтгэн хэвлүүлсэн Л.Болд, Б.Түвшинтөгс), УБ., 2017, 163-178.

²⁴ Г.Батзаяа. Дарьганга аялгуу. “Улаанбаатар их сургуулийн эрдэм шинжилгээний баг Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн нутгаар” (хээрийн шинжилгээний ангийн тайлан сэтгүүл). УБ., 2014, №4, 168-172.

²⁵ Энд академич Ш.Лувсанвандангийн боловсруулсан авианы галигаар бичсэнийг өөрчлөлгүйгээр эшлэл авлаа. IPA галигтай: *dž-tʃ*, *tš-tʃʰ*, *š-f*, *ä-æ*, *о-ə*, *и-о*, *ö-ø*, *ä-a*, *ä-ə*, *γ-k*, *b-p*, *d-t*, *t-tʰ* гэх мэтчилэн харгалзан тохирох юм.

Ийнхүү үзэмчин, харчин нь угтаа өвөр монголын аман аялгуу боловч Монгол Улсад халхчуудын дунд цөөхүүл оршин сууж буй тэдгээр хүмүүс халх аялгуунд бараг бүрэн ууссан байна. Гэвч үзэмчин аялгууныхаа уугуул шинжийг хадгалан ярьж буй ахмад настан хүмүүс цөөн байж, хэл яриа, ёс заншлаа залуус, багачууддаа сэргээн өвлүүлэхийг хичээж байна.

Халхажсан үзэмчин аялгууны талаар Д.Боролзой өгүүлэл²⁶ бичиж нийтлүүлжээ.

3.5. Халх-буриадын завсрын аман аялгуу

Цонгоол ба хамниган аялгууг бид халх-буриадын завсрын аман аялгуу гэж үзэж байна. Учрыг доор тайлбарлая.

3.5.1. Цонгоол салбар аман аялгуу

Цонгоол овогтнууд Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Ерөө, Алтанбулаг сумдад төвлөрөн, аймгийн төв – Сүхбаатар, Шаамар, Дулаанхаан тосгон, Жавхлант, Хүдэр сумдад, мөн Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Хэнтий аймгийн Биндэр, Дадал, Батширээт сумдад хэсэг бусгаар тархан сууж байна.

Халхын Цогт хунтайж 1630-аад онд улс төрийн зөрчлөөс болж халхаас шахагдан Төвөдийн зүгт орших Хөхнуур тийш цэрэг, ардаа авч дүрвэн нүүгээд, Амдо (одоогийн Хөхнуур) хүртэл довтолж, тэндээ 1637 оныг хүртэл хаан сууж байгаад, халх, ойрадын цэрэгт дарагдсан байна (Гонгор, [1970] 2015). Тийнхүү албат ард нь сарнин бутрах үед хүү Хонтогорын тэргүүлсэн бүлэг Өвөр Монголд очсон бөгөөд тэднийг ‘Хөхнуурынхан’, ‘Хөхнуураас ирэгсэд’ гэсэн утгаар Цонгоол хэмээн нэрийджээ. 1630-аад онд Халхын Цогт хунтайжийн ач хүү Охин нь Манжийн түрэмгийллийг эсэргүүцэж, өөрийн албат цонгоолчуудыг дагуулан Оросод дагаар оржээ. 1692 онд тавнангууд цонгоол овгийнхныг барьж, Сэцэн хан аймагт тушаасан боловч 1695 онд Зүүнгарын Галдан Бошгот хаан халхад довтлон ирэх үед тэд дахин Оросын Цагаан хаанд дагаар оржээ (Нацагдорж, 2015).

Өдгөө ОХУ-ын Буриад Улсын Сэлэнгэ, Зэд, Хиагт, Бичурийн аймгуудаар тархан суурьшсан цонгоолчууд буй. 1911-1921 онд Монголд нүүж ирсэн буриадуудыг 6 хошуунд тараан суулгаснаас “Ерөө голын буриад хошууг 1925 онд байгуулж, 1931 онд Сэлэнгэ аймгийн Ерөө сум болсон бөгөөд их төлөв цонгоол, хамниган байдаг” (Гантөмөр, 2017: 22-27).

Аялгууны онцлог: Цонгоолчууд халх, буриад аялгууны дундын шинжтэй байдаг тухай Ц.Б.Будаев “а). цонгоол аялгуу нь халх аялгууны онцлогийг хадгалсан, б). түүнд буриадын утга зохиолын хэл буюу хори буриадын аялгуу нөлөөлсөн” (1965: 180) хэмээн дүгнэсэн байна. Мөн Ш.Лувсанвандан “Орчин цагийн монгол хэлний завсрын аман аялгуунуудыг ажиглавал,... зах хязгаарынхаа аль нэг аялгуутай хутгалдсан байдалтай ажээ... Жишээлбэл, төв ба умард аялгууны завсрын аман аялгуу болох Сэлэнгийн аман аялгуу нь авианыхаа системээр халх аман аялгуутай бараг адил боловч үгсийнхээ сангийн талаар буриад аялгуутай нэлээд ойролцоо” ([1959] 2002: 53) хэмээн тэмдэглэж байжээ. Тухайлбал, буриад аялгууны нэн тэргүүний онцлог шинж болох, бусад аялгууны [ts], [tʃ], [tsʰ], [tʃʰ], [s] гийгүүлэгчийн байранд хэлдэг сул шүргэх [z], [ʒ], шүргэх [s], [ʃ] болон төвөнхийн [h] гийгүүлэгч, гарахын тийн ялгалын [ha:] нөхцөл зэрэг нь цонгоолд байдаггүй. Энэ нь олон жил (наад зах нь 320 гаруй жил) буриадуудтай хамт нутаглаж ирсэн боловч халх аялгууныхаа шинжийг зарим талаар огт алдаагүйг харуулна. Гэхдээ [h] хэлдэггүй ч халх аялгуунд жишээлбэл [sənəx] – сөнөх гэж хэлдгийг буриадад [huəxə] – хүнэх гэж хэлдэг бол цонгоолд [хүнэх] – хүнэх гэж хэлдэг боловч эхний гийгүүлэгчийг буриадын [h]-ээр биш, халхын [x]-ээр хэлдэг. Үүнээс, цонгоолчууд нь буриадажсан боловч [h] гийгүүлэгчийг буриад шиг хэлэх өгүүлүүр зүйн бааз үгүй нь харагдаж байна. Цонгоолд харин халх, буриадын алинд ч байдаггүй [ei] хос эгшигтэй, үгийн тэргүүн бус үедээ богино [e] эгшигийг тод хэлдэг зэрэг өөрийн гэсэн өвөрмөц онцлогууд бий. Бас зарим үгийг халх, буриад аялгууны дундын

²⁶ Д.Боролзой. Монгол хэлний үзэмчин аялгууны өнөөгийн нөхцөл байдлын судалгаа. “Хэл зохил судлал”. УБ., 2025. Том. XVIII (50). 2025. Facs 5.

шинжтэй хэлдэг. Жишээ нь: *малынхаа* гэдэг үгийг халхад [maŋ:ŋxa:], хори-ага буриадад [malæ:ŋka:] гэж байхад цонгоолд [malɪ:ŋka:] гэнэ. *уулнаас* гэдэг үгийг халхад [o:lna:s], хори-ага буриадад [χadaha:] гэж байхад цонгоолд [χadna:s] – *хаднаас* гэх жишээтэй.

Г.Гантогтох нар 1977 онд Сэлэнгэ аймгийн цонгоолчуудын хэл яриаг судлаад “*Цонгоол бол монгол нутгийн буриад аялгуутнуудаас монгол бичгийн хэлнээс хамгийн их холдсон, хамгийн их халхажсан. Халх, буриадын завсрын шинжтэй. Энэ нь цонгоолууд хэсэг бусгаараа тархан сууж байсан, энд тэнд нүүдэллэж байсан зэрэг түүхтэй нь шууд холбоотой юм. 50-аас доош насны хүмүүс нь халхаар ярьдаг, 60 орчим, түүнээс дээш насны хүмүүс нь халх, буриад завсрын аман аялгуутан болжээ*” (1977: 5) хэмээн дүгнэсэн байна.

Өдгөө Сэлэнгэ аймгийн цонгоолчууд халхчуудын дунд сууж, бараг бүрэн халхаар ярьдаг болсон бол хори-агын буриадуудын дунд суурьшин суусан Хэнтий, Дорнод аймгийн цонгоолчууд харьцангуй буриаджуу аялгуугаар ярьж, хувцас хунар, ахуй амьдрал нь ч тэдэнтэйгээ ойролцоо байдаг. Иймээс тэднийг монгол хэлний нутгийн аялгууны хуваарилалтад халх-буриадын завсрын аман аялгууны нэг салбар гэж үзэх нь зүйтэй юм.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 1977 онд Ж.Цолоо, Г.Гантогтох нарын, 1982 онд Г.Гантогтохын ахалсан анги, МУБИС-аас 1993 онд Ж.Санжаа, Р.Чүлтэмсүрэн нарын ахалсан анги, 2024 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс Г.Батзаяа, Б.Отгончимэг нар тус тус явж, цонгоол аялгууг судалж, хэрэглэгдэхүүн цуглуулжээ. Буриад хэлний цонгоол аман аялгууны талаар Ц.Б.Будаев (1965, 1968), К.Л.Аюшеев (2001) нар судалсан бол монгол хэлний халх-буриадын завсрын цонгоол аман аялгууны талаар Б.Отгончимэг (2024) өгүүлэл²⁷ нийтлүүлжээ.

3.5.2. Монголжсон хамниган салбар аман аялгуу

Хамниганчууд Монгол Улсын Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Булган, Баянтүмэн, Чулуунхороот сумд; Хэнтий аймгийн Дадал, Норовлин сумд; Сэлэнгэ аймгийн Ерөө суманд буриадуудтай айлсан, холилдон суудаг.

Тэдний уг гарвалийн тухай Б.Ринчен “*Ер, хамниган ястныг нийт дор авч өгүүлбээс, монгол, түрэг лүгэ зэрэгцэн нангиад /хятад/ сударт дөрвөн мянган жилээс нааш оролцож ирсэн хуучны их үндэстэн даруй мөн болох бөгөөд дорно дахь гадаад далайн эргээс өрнө дэх их Алтай хүртэл ба монгол говиос умард мөсөн далай хүртэл тархаж түгсэн нь цаг үес ба газар оронд алдар адилгүй боловч бие бялдын шинж ба хэлний шинж нь нэгэн үндэстний ард хэмээн мэдэгдмээр баймой. /Солоон, манж хэл, хамниган хэл нэгэн төрөл буюу/*” (Ринчен, 1969: 8) хэмээсэн бол хожим Өвөр Монголын эрдэмтэн Ж.Сэндмаа Алтай язгуурын хэлний нэг болох манж түнгүс төрлийн эвенк хэлтэн буюу эвенкчүүд нь МЭ I зуунд өмнө талаараа Хятан улстай хил залган оршиж байсан Дундад улсын зүүн хойд орны Шивэй хэмээх анчин ахуйтай нэгэн угсаатнаас гаралтай. Шивэйчүүдийн зарим нь Дагуур, Манж, Монгол угсаатанд уусан нэгдэж, голдуу хос хэлтэн болсон бөгөөд харин бусдад уусалгүй эх хэлээ хадгалан үлдсэн нь Орчоон ба Эвенк үндэстнүүд болох зэрэг судалгаа хийжээ. Монголчуудтай нийлсэн нь буриад угсаатантай холилдон сууж, хамниган гэгдэх болжээ. ‘Хамниган’ хэмээх нэрийн талаар ‘хам нэг зон’ гэсэн буриад үг, ‘бөөгийн шашинтан’ гэсэн түнгүс үг (Сэндмаа, 2011: 47), ‘камни (хад асга)’ гэсэн үг, ‘Кабканас (энэ нь хавхчин гэсэн үг)’ нэр, Киданы нэгэн овгийн нэр (Мөнхжаргал, 2018: 22) гэсэн адил бус тайлбарууд байдаг.

Аялгууны онцлог: Б.Ринчен “Өдгөө бүхүй хамниган, монголын дунд цөөн тооны хүмүүс суух тул эх хэлээ мартаж, монгол халхын хэлтэй болсон ба... ахмад насны хамниганы нэгэн хэсэг нь орчин хавийн монголчуудаас баахан өөр татлагатай аман аялгуугаар хэлэлцдэг... тэр нь хамнигацуулын аманд үлдсэн монгол аман аялгууны зүйл байнам” (1969: 12, 81) гэжээ. Сүүлийн үед Ж.Янхунен “Монгол хэлнүүд” бүтээлдээ “*Хамниган гэдэг нэр томьёо нь өөрөө Эвенкийн монгол нэр юм. Хамниган эвенк нь бие даасан хэл биш, харин хойд түнгүс эвенк хэлний аялгууны нэг хэсгийг бүрдүүлдэг. Хамниганы монгол хэлийг өөр ямар ч монгол хэлний аялгуу гэж үзэж болохгүй... монгол хэл нь хамниганчуудын зонхилох олон нийтийн хэл бол хамниган*

²⁷ Б.Отгончимэг. Цонгоол аялгуутны ба угсаатны үндсэн онцлог, “Гуманитарное образование в современных условиях” Улан-Удэ, 2024. 27-31.


эвенк хэлийг зөвхөн гэр бүлийн хүрээнд ашигладаг” (2003: 83) гэсэн байна. Өдгөө тэд үндсэндээ халхажсан бөгөөд тодорхой үлдсэн онцлог гэвэл: ‘х’ гийгүүлэгчийг эр чанга үгэнд [q^h], эм сул үгэнд [k^h] гэж чанга хамжиж хэлдэг. Үгийн сангийн цөөнгүй хувь нь буриад аялгуутантай ижилссэн байна. Тиймээс ‘Монголжсон хамниган’ хэмээн нэрлэж, халх-буриадын завсрын аман аялгуу гэж үзэж байна.

1959 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс Л.Мишиг ахлагчтай анги Хэнтий аймгийн Биндэр, Дадал сумын буриад болон хамниган аялгууг судалж материал цуглуулсан бөгөөд 1959 онд Л.Мишиг өгүүлэл²⁸ нийтлүүлж, 1969 онд Б.Ринчен “Монгол ард улсын хамниган аялгуу” хэмээх нэг сэдэвт бүтээл хэвлүүлжээ.

4. Судалгааны үр дүн

Аливаа хэл, аялгууны авиа, үгийн бүтэц, үгийн сангийн бүрэлдэл, утга, өгүүлбэрийн айзам хэмнэл зэрэг нь тухайн хэл, аялгуутан ард түмний угсаа гарваль, түүхэн замнал, амьдран аж төрж ирсэн газар нутаг, хил залгаа хэл, аялгуу, өв соёл, зан заншил, эрхэлж ирсэн аж ахуй, урлаг соёл зэрэг бүхий л зүйлтэйгээ нягт холбоотой байдаг. Гэвч тэдгээрийг холбон судалсан бүтээл өнөө хэр ховор байна.

Бид дээрх зүйлсийг тодорхой хэмжээгээр харгалзан, халх аялгуу өнөөдөр ямар байгааг тойм боловч бичлээ. Монгол хэлний халх нутгийн аялгуун дотор ийнхүү газар нутгийн байршил болон уг гарлаараа нэгдсэн, авиа зүй, хэл зүй, үгийн сангийн хувьд өөр өөрийн онцлогтой боловч халх аялгууныхаа ерөнхий онцлогийг болон монгол хэлнийхээ нийтлэг шинжийг хадгалж, бичгийн хэлэндээ захирагддаг дөрвөн аман аялгуу байна. Мөн угсаа гарвалийн хувьд халх, жич монголжсон эвенк (хамниган) боловч нэгэн нутагт олон жил хамт суурьшсан буриад аялгуутныхаа хэл яриа, зан заншил, ахуй соёлд тодорхой хэмжээгээр адилсаж, хоёр аялгууны аль алины нь онцлогийг авиа зүй, хэл зүй, үгийн сангийн түвшинд хүртсэн буриад-халхын завсрын аман аялгуу байна. Голдуу угсаатны доторх овог, нутаг ус, түүхэн замналаараа нэгэн бүлэг болж, авиа зүй, хэл зүй, үгийн сангийн хувьд тодорхой, цөөн онцлогтой боловч төв халх, баруун халх, зүүн халх, халх-буриадын завсрын аман аялгууны болон халх нутгийн аялгууныхаа ерөнхий онцлогийг хадгалсан дээрх арван нэгэн салбар аман аялгуу байна гэж бид тооцлоо. Схемчлэн харуулбал:



Бүдүүвч 1.

Монгол хэлний халх нутгийн аялгуун дахь аман аялгуу (салбар аман аялгуу)-ны бүрэлдэхүүн

²⁸ Л.Мишиг, “Монгол ард улсын зарим нутгийн хамниган аялгууг сурвалжилсан нь”, УБ., 1959, 35 тал; “Монгол, манж хэл бичиг судлалын өгүүллүүд”, 2016

5. Дүгнэлт

Монгол хэлний нутгийн аялгуу судлал гадаад, дотоодын олон зуун эрдэмтдийн нөр их хөдөлмөрөөр өнөөг хүртэл наад зах нь 200 жил хөгжихдөө нутгийн аялгуу – аман аялгуу – салбар аман аялгууг бүртгэх, ангилах, тус тусын онцлогийг судлан тоочих (голдуу авиа зүйн) судалгаа харьцангуй хангалттай, бүрэн болжээ.

Бид дурдсан төслийн хүрээнд “Монгол хэлний нутгийн аялгуу, төрөл хэл судлалын ном зүйн бүртгэл”-ийг 2024 оны эхээр хэвлүүлсэн билээ. Үүнд: ном бүтээл (ганц сэдэвт зохиол /монограф, диссертац/) 427, эрдэм шинжилгээний өгүүлэл 2001, – нийт 2428 бүтээлийг бүртгэн оруулсан билээ (Батзаяа нар, 2024). Үүнээс: нийт бүтээлийн тоог 100% гэж үзвэл нутгийн аялгуу, төрөл хэлнүүдийг тус тусад нь судалсан бүтээл 86,4%-ийг, харин хоёроос дээш аялгуу, төрөл хэлийг өөр хооронд нь харьцуулж, эсвэл хэд хэдэн нутгийн аялгуу, төрөл хэлийг багтааж, нэгтгэн дүгнэж бичсэн бүтээл 13,6%-ийг эзэлж байна.

Харьцуулсан судалгааны бүтээлийг харвал, зарим нь монгол хэлнээс салбарлан хөгжсөн нийт төрөл хэлнүүдийг тэдгээрийн голлох аялгуунуудаар төлөөлөл болгон судалсан бүтээлүүд, эсвэл өөр хоорондоо ямар нэг байдлаар ижил төстэй боловч ялгаатай талыг харьцуулах шаардлагатай гэж үзсэн аль нэг хоёроос гурван хэл, аялгууг харьцуулсан бүтээл зонхилж байна. Нэгтгэн дүгнэсэн бүтээлүүдийг харвал, голдуу аялгуу бүрийн онцлог шинжийг ар араас нь өрөн, тоочиж бичсэн байна. Харин нэг нутгийн аялгуун доторх аман болон салбар аман аялгуунуудыг өөр хооронд нь харьцуулан судалсан бүтээл маш ховор байна.

Аливаа хэлнээс салбарлан бий болсон төрөл хэл, түүний аялгуунууд нь эх хэлнийхээ үнэт зүйлсийг тээгч, тухайн хэлний шинжлэлийн нэгэн гол түлхүүр болж байдаг. Нэг талаас түүхэн сурвалж бичгүүд нь тухайн хэлний туулж ирсэн хөгжлийн замналыг илтгэн харуулах бичгээр хадгалагдаж ирсэн үнэт судар, нөгөө талаас олон аялгууны бодит баримтууд ард түмний амьдрал, аж төрлөөр дамжин хадгалагдаж ирсэн аман судар, энэ хоёр нийлээд тухайн хэлний өнгөрсөн түүх, одоогийн зүй тогтол, ирээдүйн чиг хандлагыг илтгэн харуулах эд эсүүд юм. Тухайлбал, уйгуржин монгол, дөрвөлжин бичгийн дурсгалууд болон Юань гүрний үед хятад, араб үсгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсгалуудаас халх аялгууны, тод үсгийн дурсгалуудаас XVII-XVIII зууны ойрад аялгууны шинжийг, вагиндра үсгийн дурсгалуудаас XIX-XX зууны буриад аялгууны шинжийг баримжаалан мэдэж болдог бол монгол хэлнээс харьцангуй эрт үед салбарлан гарсан дагуур, монгол, дуншаан, бао-ань, могол зэрэг хэлнээс болон өдгөө салбарлан хөгжиж буй өмнөд монгол, буриад, халимаг хэл, тэдгээрийн олон аялгуунаас монгол хэлний янз бүрийн үе-шатны зарим онцлог шинжийг мэдэж болдог билээ.

Монгол хэлний доторх тухайн нэг хэл, аялгуутан нэгээс гурван улсын хил дамнан, олон муж, аймаг, суманд тархан суурьшиж, хэдэн зуун жил тусгаар аж төрж ирсэн боловч уугуул язгуур онцлогоо ямар нэг хэмжээнд хадгалсаар байна. Гэвч нөгөө талаас, Монгол Улсын монгол хэлний олон аялгуу нь бичгийн хэлний суурь – халх аялгуундаа, хилийн чанад дахь монгол хэлнүүд нь тус тусын голлох аялгуундаа уусан жигдрэх, суурьшин буй улс гүрнийхээ хэлтэй холилдох үйл явц эрчимтэй болсоор байна.

Энэ бүхнээс дүгнэхэд, монгол хэлний нутгийн аялгуу судлалын ирээдүйд дараах гурван асуудлыг чухалчлан анхаарууштай болжээ. Үүнд: Нэгдүгээрт: Бага судлагдсан аялгуунуудыг судалж гүйцээх, сайн судлагдсан аялгуунуудыг ч дахин судалж өнөөгийн байдлыг тогтоох, Хоёрдугаарт: Монгол хэлний аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуунуудыг хам ба цуваа цагт өөр хооронд нь харьцуулан судалж, нэгтгэн дүгнэх, Гуравдугаарт: Нутгийн аялгууны онцлогийг байгаль, газар нутаг, түүх, соёлын өвтэй нь холбон цогц судалгаа хийх чухал шаардлагатай байгааг тэмдэглэе. Чухам энэ үүднээс тус өгүүлэлд монгол хэлний халх аялгууны доторх аман болон салбар аман аялгуунуудын талаар тоймлон бичлээ.

6. Талархал

“Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” сэдэвт суурь судалгааны төслийн хамт олондоо болон халх аялгууны талаарх судалгааг хамтран хийсэн доктор /Ph.D/ Д.Боролзой, доктор /Ph.D/ Б.Отгончимэг, доктор /Ph.D/ Х.Лхагвабаяр, дарьганга аялгууг хамтран судалсан доктор /Ph.D/ Ш.Чимэдцэеэ нартаа талархал дэвшүүлэе. Халх аялгууны бүрэлдэхүүн дэх аман аялгуу, салбар аман аялгуунуудыг судлах, материал цуглуулах экспедицийн ажлын үеэр уулзаж ярилцсан нэр бүхий 73 хүнд (Г.Батзаяа нар, “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” /2025/ номын 224-227-р талд бүртгэлийн жагсаалт бий.) талархъя. Мөн бидний эхлүүлсэн “МХНАС 2024” Youtube сувагт яриа өгч, видео бичлэгээ тавиулсан дээрх салбар аман аялгуутнуудын төлөөлөгч болох Ц.Бадмилхүндэв (төв халх), Ц.Баттогтох (өвөрхангайн халх), Л.Гомбо (говийн халх), Ш.Даянжав (өрнөд халх), Ц.Сүхбаатар, Д.Нина (элжигин халх), Ж.Пүрэвдорж (сартуул), Д.Ганчөдөр (дорнод халх), Ш.Даваадорж, Ч.Шархүүхэн (дарьганга), Д.Ууганбаяр (халхажсан үзэмчин), П.Жаргал (цонгоол), Ш.Бадамгарав (монгольжсон хамниган) нартаа болон тус сувгийг нээж, бичлэгүүд болон галигийг өрж, хийж өгсөн Г.Ариун-Онон, Б.Амарбаясгалан, О.Мөнхнаран нартаа гүн талархал илэрхийлэе.

Ном зүй

А. Монгол хэлээр:

- Амаржаргал, Б.** (2007). *Халх аялгууны үгийн сан, утгын судалгаа*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК. [Amarjargal, B. *Khalkh ayalguuny ügiin san, utgyn sudalгаа* [A Studies on the Lexicology and Semantics of the Khalkha Dialect.]. Ulaanbaatar: Mönkhiin üseg. 2007.]
- Бадамхатан, С.** (1987). *БНМАУ-ын угсаатны зүй*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Badamkhatan, S. *Mongol ulsyn ugsaatny züi* [Ethnography of Mongolia]. Ulaanbaatar: State Publishing Hiuse. 1987.]
- Бадма-Оюу, Б.** (2007). *Дарьгангын угсаатны зүй*. Улаанбаатар. [Badma-Oyu, B. *Darigangyn ugsaatny züi* [Ethnography of Dariganga]. Ulaanbaatar. 2007.]
- Батзаяа, Г., Отгончимэг, Б., Бай, Тулгуур.** (2024). *Монгол хэлний нутгийн аялгуу, төрөл хэлний ном зүйн бүртгэл*. Улаанбаатар: Арвай принт. [Batzaya, G., Otgonchimeg, B., Bai, Tulguur. *Mongol khelnii nutgiin ayalguu, töröl khel sudlalyn nom züin bürtgel* [Bibliography of Mongolian Dialects and Subdialects]. Ulaanbaatar: Arvai print. 2024.]
- Батзаяа, Г., Батдорж, Ц., Баярчимэг, Э.** (2022). *Нутгийн аялгуу (“Монгол хэл судлал” 15 боть бүтээлийн VI боть)*. Улаанбаатар: МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. [Batzaya, G., Batdorj, Ts., Bayarchimeg, E. *Nutgiin ayalguu* [Dialectology {Mongolian Language Studies}]. Ulaanbaatar: Institute for Mongolian Studies. 2022.]
- Биргалан Агнеш.** (2016). *Чингис хааны цагаан сэтгэлт ард түмэн*. Улаанбаатар. [Birtalan Agneš. *Chingis khaany tsagaan setgelt ard tümen* [Genghis Khan's white-hearted people]. Ulaanbaatar. 2016.]
- Будаев, Ц. Б.** (1965). Цонгольский говор. *Исследование бурятских говоров*. Улан-Үдэ, Вып-1, 151-186. [Budaev, C. B. Tsongool subdialect. *Isledovanie buryatskikh govorov*. Ulan-Üde. 1965. 151-186.]
- Гонгор, Д.** ([1970] 2015). *Qalq-a tobčiyan*. Kökeqota: Arad-un keblel-ün qoriy-a. [Gongor, D. *Khalkh tovchoon* [History of Khalkha]. Hohhot: People's Press Committee. 2015.]
- Дамдинсүрэн, Ц.** (1957). *Монголын уран зохиолын тойм*. Улаанбаатар. [Damdinsüren, Ts. *Mongolyn uran zokhiolyn тойм* [Mongolian Literature]. Ulaanbaatar. 1957.]
- Лувсанвандан, Ш.** ([1959] 2002). Монгол хэл, аялгууны учир, Улаанбаатар: 1959. *Монгол хэлний авиа зүйн онол практикийн асуудлууд* (2002). [Luvsanvandan, Sh. The Mongolian Languages and Dialects. *Mongol khelnii avia züin onol praktikiin asuudluud*. Ulaanbaatar. 2002. 38-45.]
- Лувсандэндэв, А.** ([1957] 2007). *Дариганга*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Luvsandendeв, A. *Dariganga* [Dariganga]. Ulaanbaatar: Soyombo printing. 2007.]
- Лхагвабаяр, Х.** (2014). *Eljigin qalq-a salburi aman ayalgun-u üges-ün sang-un suduly-a*. Kökeqota: öbür mongyol-un yeke surayuli. [Lhagvabayar, Kh. *Eljigin khalkh salbar aman ayalguuny ügsiin sangiin sudalгаа* [Studies on the Dariganga Lexicology of Eljigin Khalkha Subdialect]. Hohhot: Inner Mongolia University. 2014.]
- Пүрэвжав, Э., Ганболд, Д., Заябаатар, Д., Энхжаргал, С., Эрдэнэтуяа, П., Баттогтох, Г.** (2022). *Бичгийн хэл (“Монгол хэл судлал” 15 боть бүтээлийн XIII боть)*. Улаанбаатар: МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. [Pürevjav, E., Ganbold, D., Zayabaatar, D., Enkhjargal, S., Erdenetuya, P., Battogtokh, G. *Bichgiin khel* [Literary Language {Mongolian Language Studies}]. Ulaanbaatar: Institute for Mongolian Studies. 2022.]

- Санжаа, Ж., Надмид, Ж.** ([1993, 2010] 2018). *Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй*. Улаанбаатар. [Sanjaa, J., Nadmid, J. *Mongol khelnii avia züi ba avialbar züi* [The Phonetics and Phonology of Mongolian]. Ulaanbaatar. 2018.]
- Сэндмаа, Ж.** (2011). *Sendem-a. Qamniyan ewenki sudulul*. Kökeqota: Arad-un keblel-ün qoriy-a. [Sendmaa, J. *Khamnigan evenk sudlal* [Studies on the Khamnigan Evenki]. Hohhot: People's Press Committee. 2018.]
- Хадбаатар, Ш.** (2006). *Монголчуудын овог, отог, угийн бичиг*. Улаанбаатар. [Khadbaatar, Sh. *Mongolchuidyn ovog, otog, ugiin bichig* [Mongolian genealogy]. Ulaanbaatar. 2006.]
- Цолоо, Ж.** ([1982] 2011). *БНМАУ-ын нутгийн аялгуу ("Хэл зохиол судлал", Боть XVIII. УБ., 1982). Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу*. [Tsoloo, J. *Orchin tsagiin mongol khelnii nutgiin ayalguu*. Улаанбаатар: Содпресс. [Dialects of Modern Mongolian Language]. Ulaanbaatar: Sodpress. 2011.]

Б. Гадаад хэлээр:

- Владимирцов, Б. Я.** (1929). *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*. Ленинград. [Vladimircov, B.Ya. *Sravnitelnaya grammatika mongol'skogo pismennogo yazyka i khalkhaskogo narechiya* [Comparative grammar of the Mongolian written language and the Khalkha dialect]. Leningrad. 1929.]
- Дорж Банзаров.** (1955). *Объяснение монгольской надписи на памятнике князя Исунке, племянника Чингис-хана, Собрание сочинений*. Москва. [Dorj Banzarov. *Obiyasneniye mongol'skoi nadpisi na pamyatnike knyazyu isunke, pemyannika čingis-khana. Sobranie sočinenii* [Explanation of the Mongolian inscription on the monument of Prince Isunke, nephew of Genghis Khan, Collected Works]. Moscow. 1957.]
- Санжеев, Г. Д.** (1953). *Сравнительная грамматика монгольских языков*. Москва. [Sanjeev, G. D. *Sravnitelnaya grammatika mongol'skikh yazykov* [The Comparative Grammar of Mongolian languages]. Moscow. 1953.]
- Шастина, Н. П.** (1957). *Шара Туджи (Erten-ü Mongyol-un qad-un ündüsün-ü yeke sir-a tuyuji orusiba). Монгольская летопись века. Сводный текст, перевод, введение и примечание*. Москва-Ленинград. 1957.
- Янхунен, Ж.** (2003). Janhunen, J. (ed.), *The Mongolic Languages, Pouledge Language Family Series*. London, New-York. 2003.